

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

“ГОВЬ, ХЭЭРИЙН БҮСИЙН НЕОЛИТЫН СУДАЛГАА” ТӨСЛИЙН 2017 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

Төслийн гүйцэтгэгч:

Д.Одсүрэн – ШУА-ийн Түүх, Археологийн
хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Д.Бөхчулуун – АНУ-ын Йелийн Их Сургуулийн
докторант

Л.Яанз – доктор (Ph.D). Канадын Трентийн Их
Сургуулийн судлаач

А.Розен – доктор, профессор. АНУ-ын Техасын Их
Сургуулийн судлаач.

Санхүүжүүлэгч

байгууллага:

Тайлан өмчлөгч:

Franklin Research Grant

Монгол улсын ШУА-ийн Түүх, Археологийн
хүрээлэн. Улаанбаатар-13343, Жуковын гудамж
77, ШУА-ийн нэгдсэн I байр
Утас: +976 11-458305/455028
Э-хаяг: info@history.mas.ac.mn

Улаанбаатар
2018

Улсын бүртгэлийн
дугаар.....

Аравтын бүтэн
ангилалын код

Нууцын зэрэглэл:

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар:

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

“ГОВЬ, ХЭЭРИЙН БҮСИЙН НЕОЛИТЫН СУДАЛГАА” ТӨСЛИЙН 2017 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

Төслийн гүйцэтгэгч:

Д.Одсүрэн – ШУА-ийн Түүх, Археологийн
хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
Д.Бөхчулуун – АНУ-ын Йелийн Их Сургуулийн
докторант
Л.Яанз – доктор (Ph.D). Канадын Трентийн Их
Сургуулийн судлаач
А. Розен – доктор, профессор. АНУ-ын Техасын
Их Сургуулийн судлаач

Санхүүжүүлэгч
байгууллага:

Franklin Research Grant

Тайлан өмчлөгч:

Монгол улсын ШУА-ийн Түүх, Археологийн
хүрээлэн. Улаанбаатар-13343, Жуковын гудамж
77, ШУА-ийн нэгдсэн I байр
Утас: +976 11-458305/455028
Э-хаяг: info@history.mas.ac.mn

**Улаанбаатар
2018**

ГАРЧИГ

| | |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| УДИРТГАЛ | 5 |
| 1. МОНГОЛ ОРНЫ ЗҮҮН БҮС НУТГИЙН ЧУЛУУН ЗЭВСГИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ | 7 |
| 2. ЗАРАА УУЛ ОРЧМЫН ГАЗАРЗҮЙН БАЙРЛАЛ | 14 |
| 3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ | 17 |
| 4. ХАЙГУУЛ СУДАЛГАА | 19 |
| 5. МАЛТЛАГА СУДАЛГАА | 29 |
| 5.1. Чулуун зэвсгийн дурсгалын малтлага | 29 |
| 5.2. Чулуун байгууламжит дурсгалын малтлага | 37 |
| | 45 |
| 5. ТОВЧ ҮР ДҮН | |
| 6. НОМ ЗҮЙ | 48 |
| 7. ХАВСРАЛТ | 51 |
| Зургийн тайлбар | |
| Зураг-1. Зараа уулын топографийн зураг | 15 |
| Зураг-2. Баруун булагийн чулуун зэвсгийн олдворт газар болон дараасгүй булш | 19 |
| Зураг-3. Баруун булагаас илрүүлсэн дараасгүй булш | 20 |
| Зураг-4. Баруун булагаас илрүүлсэн дараасгүй булшны олдворууд | 21 |
| Зураг-5. Баруун булагаас илрүүлсэн дараасгүй булшны олдворууд | 21 |
| Зураг-6. Баруун булагт ил хөрсний элэгдлээр ил гарч устсан булш ба газардээр тархсан ваарны хагархайнууд | 22 |
| Зураг-7. Адуун худагийн чулуун зэвсгийн олдворт газар | 23 |
| Зураг-8. Энгэр шар бүрдийн чулуун зэвсгийн суурин | 23 |
| Зураг-9 Хөндлөнгийн голын чулуун зэвсгийн олдворт газруудын тэмдэглэгээ | 24 |
| Зураг-10 Өлзийн булаг ба сорьц малтлагууд | 25 |
| Зураг-11 Салаа булагийн чулуун зэвсгийн олдворт газруудын тэмдэглэгээ | 26 |
| Зураг-12 Салаа булагт хийсэн сорьц малтлага | 27 |
| Зураг-13 Салаа булагт хийсэн малтлагаас илрүүлсэн зарим чулуун зэвсгүүд. Зэв-1, 2, 4; үлдэц-3, 7; ирлэсэн ялтас-5, ирлэсэн залтас-6; зуулга-8 | 28 |
| Зураг-14 Зараа уулын археологийн дурсгалын байршил | 29 |
| Зураг-15 Зараа уулын Ил энгэрийн 2-р суурин | 30 |
| Зураг-16 Зараа уулын Ил энгэрийн 2-р суурин. 3-р малтлага | 31 |
| Зураг-17 3-р малтлагын явц | 31 |

| | |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Зураг-18 3-р малтлагын 1-р давхарга. Ооль | 31 |
| Зураг-19 Зараа уулын палеолитын суурин | 32 |
| Зураг-20 Оцол хадны палеолитын суурин | 33 |
| Зураг-21 Зүүн Шовхын палеолитын суурин | 34 |
| Зураг-22 Зүүн Шовхын палеолитын сууринд хийсэн сорьц малтлагаас илэрсэн галын ором | 35 |
| Зураг-23 Зүүн шовхын палеолитын суурингийн чулуун зэвсгүүд. Хянгар-1, 3, 5, 7, 8-10; үлдэц-2, шүдлэг-хүнхэр иртэй зэвсэг-4; хүнхэр иртэй холтослуур маягийн зэвсэг-6, ялтас-11 | 36 |
| Зураг-24 Ил Энгэрийн орчимд орших улаан зуух хэлбэрийн булш | 37 |
| Зураг-25а EX-1-р булш (анхны байдал) | 38 |
| Зураг-25b EX-1-р булшны хашлага ба дараас | 39 |

Хавсралтын тайлбар

| | |
|-----------------------------------------------------------|----|
| Хавсралт-1. Хээрийн судалгааны ажлын удирдамжийн хуулбар | 50 |
| Хавсралт-2. Хээрийн судалгааны ажлын зөвшөөрлийн хуулбар | 54 |
| Хавсралт-3. Хээрийн шинжилгээний ажлын томилолтын хуулбар | 55 |

УДИРТГАЛ

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, АНУ-ын Аризонагийн Их Сургууль, Канадын Трентийн Их сургуулийн судлаач, доктор Л.Яанзтай хамтран “Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа” нэртэй эрдэм шинжилгээний төслийг 2013 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

Энэхүү хамтарсан төслийн зорилго нь Монгол орны говь, хээрийн бүс нутгаас сүүлчийн их мөстлөгийн дараах үеийн эртний хүний ул мөр болох бууц, суурин зэрэг дурсгалуудыг шинээр илрүүлэх, малтан судлах, тухайн үеийн хүмүүсийн ахуй амьдралын хэв маяг, аж ахуйн асуудлыг тодруулах, уур амьсгал, байгаль орчны өөрчлөлтийг тодорхойлох, тухайн үеийн түүхийн балархай асуудлуудад хариулт өгөх эх хэрэглэгдэхүүнийг бий болгох, түүхийг шинэ баримт, үзэл хандлагаар баяжуулахад чиглэгдэж байгаа болно.

Хамтарсан төслийн хүрээнд хээрийн судалгаа хийхээр төлөвлөсөн бүс нутгийн чулуун зэвсгийн дурсгалт газруудын олонх уур амьсгалын гөхцөл байдлаас шалтгаалан ил суурин хэлбэрээр, үе үеийн олдворууд газрын хөрсөн дээр холилдон оршдог бөгөөд өмнөх судалгаанаас үзэхэд, он цаг тогтоох лабораторийн нарийвчилсан шинжилгээ харьцангуй бага хийгдсэн байдаг. Тиймээс бид илрүүлсэн дурсгалуудын насжилтыг лабораторийн судалгаанд тулгуурлан аль болох нарийвчлан тодорхойлох, цаашид өргөн хүрээний судалгаанд ашиглагдаж бааз суурийг бий болгохыг мөн зорьж байна.

Өнөөгийн байдлаар хамтарсан төслийн баг Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан уулын орчимд Булагийн эхэн, Дунд булаг, Адагийн булаг, Тогоотын гол, Дэлгэрхаан уулын зүүн урд орших эртний нуурын савын ар, Зараа уул, Улаан зуух [Амартүвшин нар., 2013], Дарьганга сумын нутаг Молцог элс орчимд Өлзийн булаг, Салаа булаг, Ганга нуурын зүүн эрэг, Сүмтийн нуур, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутагт, Хэрлэн голын эрэгт орших Баян хошуу зэрэг газруудаас шинэ чулуун зэвсгийн дурсгал илрүүлээд байна.

Мөн Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Зараа уулын шинэ чулуун зэвсгийн сууринд 2015 оноос эхлэн суурин малтлага судалгааны ажил хийж байна.

Хамтарсан төслийн хүрээнд 2017 онд бид өмнөх жилүүдэд тухайн бүс нутагт хийж байсан хайгуул болон Зараа уулын шинэ чулуун зэвсгийн дурсгалт газарт хийж буй малтлага судалгааг үргэлжлүүлэх, мөн Зараа уулын шинэ чулуун зэвсгийн олдворт газруудын ойр орчимд байрлах чулуун байгууламжит дурсгалуудыг малтан судлах зорилт тавьсан.

Энэ оны хээрийн шинжилгээний ажил 6 дугаар сарын 15-наас 7 дугаар сарын 14-нийг хүртэл 31 хоногийн хугацаанд үргэлжилсэн бөгөөд ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн Археологийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Одсүрэн, АНУ-ын Йэлийн Их Сургуулийн докторант Д.Бөхчулуун, Канад Улсын Трентийн Их Сургуулийн судлаач, доктор (Ph.) Л.Яанз, АНУ-ын Техасын Их сургуулийн судлаач, доктор, профессор А.Розен, жолооч Чинзориг, Отгонбаатар, тогооч болон эрдэм шинжилгээний 5 туслах ажилтны бүрэлдэхүүнтэй хээрийн шинжилгээний баг ажиллав.

1. МОНГОЛ ОРНЫ ЗҮҮН БҮС НУТГИЙН ЧУЛУУН ЗЭВСГИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ

Монгол орны зүүн бүс нутагт Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгийн зүүн хэсгийн нутаг дэвсгэр хамаарна.

Тухайн бүс нутгийн чулуун зэвсгийн судалгаа ХХ зууны эхэн хагаст эхэлсэн бөгөөд 1933-1934 онуудад ШУХ-ийн урилгаар ажилласан Оросын судлаач Д.Д.Букиничийн тайланд Өмнөговьос Даш, Дорнодоос Буддарь нарын хүмүүс чулуун зэвсгийн олдвор цуглуулан илгээж байсан тухай тэмдэглэсэн байдаг.

1933-1934 онд Д.Д.Букинич Халхын голын сав газраар хайгуул хийж, неолитын үеийн сонирхолтой олдворуудаас гадна палеолитын үеийн зэвсэг багажийн зүйл цөөнгүй цуглуулжээ [Букинич, 1934].

1949 онд С.В.Киселевын удирдсан Монгол-Зөвлөлтийн түүх-этнографийн хамтарсан экспедицийн бүрэлдэхүүнд А.П.Окладниковын удирдсан чулуун зэвсгийн дурсгал судлах анги ажиллаж, Хиагтаас Улаанбаатараар дайран баруун зүг Хархорин хүртэл, зүүн тийш Хэрлэн, Халх голын сав газраар, өмнө зүгт улсын хил хүртэл хайгуул судалгаа хийсэн байна [Окладников., 1951].

Х.Пэрлээ 1951-1955 оны хооронд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг Улаан-Зээг, Хэнтий аймгийн Баянхутаг сумын нутаг Хэрлэнгийн Баянцогт овоо, Батширээт сумын нутаг Өглөгчийн хэрэм, Рашаан хад зэрэг газруудаас хуучин чулуун зэвсгийн зүйлс, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутаг Гүрэмийн нуур, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг Дулааны говьд шинэ чулуун зэвсгийн дурсгал байгааг тус тус илрүүлжээ. 1954 онд газарзүйч О.Намнандорж Сүхбаатар аймгийн Урт сумын нутгийн зүүн зах Их айлын манхан болон Долир манхнаас шинэ чулуун зэвсгийн зүйлс, 1955 онд эрдэм шинжилгээний ажилтан А.Лувсандэндэв Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг Дарига овоо хэмээх газраас шинэ чулуун зэвсгийн үеийн тарианы нухуур зэрэг олдвор, мөн тус сумын нутгаас эрдэм шинжилгээний ажилтан Ж.Дүгэрсүрэн шинэ чулуун зэвсгийн зүйлсийг илрүүлжээ [Доржсүрэн, 1957].

1950-1956 онуудад Монголын археологичид Ховд, Өвөрхангай, Архангай, Говь, Булган, Дорноговь аймгийн нутгуудаас илрүүлсэн хуучин чулуун зэвсгийн үеийн дурсгалт газруудын чулуун зэвсгүүд Байгал нуур, Хиагт орчмоос илрүүлсэн палеолитын дурсгалуудын чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга барилтай ижил шинжтэй байгаад тулгуурлан Монгол оронд амьдарч байсан эртний хүмүүс хөрш зэргэлдээ Сибирийн эртний хүмүүстэй тодорхой харилцаа холбоотой байсан гэсэн

дүгнэлтийг хийж байжээ [Доржсүрэн, 1957а: 4, 6]. Монголын археологичид энэ үеэс эхлэн мезолитын дурсгалуудыг ангилах оролдлогыг хийж эхэлсэн байна. Энэ үед холбогдуулан үзэж болох олдворуудыг Дундговь, Сүхбаатар аймгуудын нутгаас илрүүлэн олсон [Доржсүрэн, 1957а] бөгөөд тэдгээр нь дундаж хэмжээтэй хутган ялтас, шулуун суурьтай сумны зэв, шөвөг зэрэг зүйлс байжээ.

1959 оны намар “Рашаан шинжилгээний анги” Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Өглөгчийн хэрэм, Дархан сумын нутаг Цахарын рашаан, Чойбалсан аймгийн Цагаан-Овоо сумын нутаг Гурван рашааны дэргэдээс тус тус чулуун зэвсэг олсноос Цахарын рашааны дэргэдээс илрүүлсэн маажуур зэрэг 20 ширхэг чулуун зэвсэг тун сонирхолтой хэмээн тэмдэглэсэн байна [Намнандорж, 2003: 382-384].

1959 онд Дорноговь аймгийн Сулинхээр сумын Өлзийтөөс урагш 4.5 км-т жижиг нуураас холгүй орших толгойн хормойд геологич Г.Скворцов палеолит, неолитын үеийн сонирхолтой зэвсгийн зүйлсийг 2 хэсэг газраас олж түүвэрлэснийг В.Е.Ларичев, В.В.Волков нар тодорхойлон нийтлүүлжээ [Ларичев и др., 1964].

1961 онд Х.Пэрлээ, Шуберт нарын удирдсан Монгол-Германы хамтарсан археологи-угсаатны зүйн шинжилгээний анги Хэнтий аймгийн нутагт судалгааны ажил хийж Онон, Балж голын эрэг хавиас палеолит, неолитын үеийн зэвсгийн зүйлс илрүүлэн олсныг тус шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ажилласан Германы археологич Дитрих Маниа урд өмнө цуглуулсан зарим олдворын хамт нийтэлжээ [Mania, 1963].

1967-1987 он хүртэл манай оронд Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедици академич Ш.Нацагдорж, Д.Дорж, А.П.Окладников, А.П.Деревянко нарын удирдлагын дор хэд хэдэн ангийн бүрэлдэхүүнтэй ажиллажээ. Тус экспедицийн бүрэлдэхүүнд А.П.Окладников, Д.Дорж нарын удирдсан чулуун зэвсгийн дурсгал судлах анги 1967-1969 онуудад Дорнод, Дорноговь, Сүхбаатар аймгийн нутагт палеолитын үеийн дурсгалаас гадна мезолит, неолитын үеийн хэдэн арван шинэ бууц, суурин илрүүлэн Чойбалсан хотын ойролцоох Овоот, Тамсагбулаг, Хэрлэнгийн урд эрэгт неолитын үеийн булш, сууц хэд хэдийг анх удаа малтан шинжилжээ. Чойбалсан хотын ойролцоо Баруун Өлзийт хэмээх уулын зүүн хормойгоос “Хэрлэнгийн хүн” хэмээн нэрлэгдсэн нүүрийг нь баруун зүг харуулан зүүн хажуугаар нь хэвтүүлж, толгойг бөхийлгөн хоёр гарыг нь өвдөгний нь хооронд хавчуулан оршуулсан оршуулга илрүүлсэн бөгөөд оршуулгын зан үйл, байрлал зэрэгт тулгуурлан неолитын үед хамааруулан үзсэн байна. Мөн Тамсагбулагт неолитын үеийн нүхэн сууц болон 2 булшийг малтан судалсан байна [Дорж, 1969].

Тус шинжилгээний ангийн судлаачид 1969 онд Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг Ярх уулын дэргэдээс гилбэр зэвсгийн соёлын дурсгал бүхий дархны газар нээсэн бөгөөд доод палеолитын үед холбогдуулан үзжээ.

1970 онд Сүхбаатар аймгийн Хонгор сумын дэргэдэх Их-Оргио уулын хормойгоос палеолитын үеийн цөөн тооны эдлэл түүвэрлэсний дотор леваллуа маягийн цохилтын хоёр талбайт үлдэц байжээ [Дорж., 1971].

Д.Дорж “Дорнод Монголын неолит” бүтээлдээ Дорнод аймгаас илэрсэн шинэ чулуун зэвсгийн түүхэнд холбогдох 15 сууринг авч үзэн судалгааны эргэлтэнд оруулж он цаг харилцан хамаарлын асуудлыг тогтоосноос Ямаат нуурын суурин, Баруун Өлзийт, Овоот болон Тамсагбулагийн сууц бүхий неолитын дурсгалт дурсгалт газрууд томоохонд тооцогдоно. Тэрээр Сүхбаатар аймгийн нутгаас Онгон болон Баруун элс, Овон элс, Гүнбулаг, Эхэн усны баруун эрэг, Устай бургастай зэрэг дурсгалт газруудыг, Дорноговь аймгийн Сулинхээр сумын Сүлт хар овоо, Эрдэнэ сумын Дулааны говийн археологийн хэрэглэгдэхүүнийг уг нэгэн сэдэвт бүтээлдээ авч үзсэн байдаг. Түүний бүтээл нь Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгийн нутгаас олдсон неолитын дурсгалуудыг нэлээд сайн судлагдсан хөрш зэргэлдээ орны мөн үеийн дурсгалтай харьцуулан судалж Монголын неолитын чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга, түүний хөгжлийг үечлэн, улмаар тэр үеийн хүмүүсийн эрхлэх аж ахуй, нийгэм, оюун санааны хөгжлийг нэгтгэн дүгнэсэн байна. Энэ нь Монголын шинэ чулуун зэвсгийн судалгааны асуудлыг хөндсөн анхны нэгэн сэдэвт бүтээл бөгөөд чулуун зэвсгийн зангилаа асуудлуудыг тухайн үеийн олдвор хэрэглэгдэхүүний хэмжээнд бүхэлд нь авч үзэхийг зорьсон юм [Дорж, 1971].

Монгол нутгаас олдсон палеолитын үеийн олон соёлт давхарга бүхий хоёр дахь дурсгалт газар болох Рашаан хадны сууринг Х.Пэрлээгийн удирдсан Гурван голын шинжилгээний анги 1973, 1974 онуудад малтаж эхэлсэн бөгөөд 1980 онд А.П.Окладников, Д.Дорж, 1981 онд Р.С.Васильевский, Д.Цэвээндорж нарын удирдлагаар МЗТСХЭ-ийн палеолитын дурсгал судлах анги үргэлжлүүлэн малтаж судалсан юм [Окладников и др., 1982].

1981 онд МЗТСХЭ-ийн чулуун зэвсэг судлалын анги Улаанбаатараас Өндөрхаан орох төв замын дагуу Хэнтийн Цэнхэрмандал сумын нутгаас дээд палеолитын үед холбогдох үлдэц, ялтас, залтас түүвэрлэсэн байна. Үүнээс гадна Рашаан хадны баруун талд орших Ханангийн жалганаас үлдэц, хусуур зэрэг палеолитын үед холбогдох нэлээд тооны эдлэл олжээ.

1981-1990 онд Дорнод Монголын бүс нутагт чулуун зэвсгийн судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй бөгөөд энэ нь МЗТСХЭ тус орны чулуун зэвсгийн

үеийн судалгааг бүсчлэн, Алтайн нуруунаас эхлэн явуулах болсонтой холбоотой юм.

1990-1993 онд Монгол-Японы хамтарсан “Гурван гол” төслийн хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд оролцсон археологичид Хэнтийн нурууны салбар уулс, Хэрлэн, Онон голын сав газраас хэд хэдэн шинэ суурин газрыг илрүүлэн, олон тооны чулуун зэвсэг түүвэрлэсний нэлээд хувь нь палеолитын үед холбогдох зэвсгийн зүйлс байжээ [Гурван гол., 1990, 1991, 1992, 1993]. Үүнд, 1990 онд Хэрлэн голын эхэн урсгалын баруун эрэг дагуу, Богдын голоос дээш Хөшийн гол, Баруун Бүрхийн голын дунд орших Намсрайн овоо (ухаа)-ны орчим, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Номгон уулын энгэрээс баргил залтас, хянгар маягийн зэвсэг, Хэрлэн голын баруун эрэг, Зүүн Байдлагийн гол, Тогос уул, Сангайн ам, Сүүжийн дэнж, Номгон толгой, Зорголын шар хад, Хустын булаг [Гурван гол., 1990] зэрэг газраас палеолитын үед холбогдох баргил залтас, дугуй үлдэц, хусуур, үзүүр мэс, гилбэр маягийн эдлэл нэлээд хэмжээгээр олджээ.

1991 онд тус шинжилгээний ангийнхан Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумын нутаг Онон, Хурхын голын сав газарт ажиллахдаа чулуун зэвсгийн зүйлс цуглуулснаас Батширээт сумын Ёлын байц, Биндэрийн Рашаан хад, Асгат уулын энгэр, Өглөгчийн үзүүр, Ганц модны жалга зэрэг газраас олдсон баргил хянгар, хусуур, залтсан хусуур, дугуй үлдэц зэрэг олон эдлэл нь палеолитын үед холбогдоно [Гурвангол, 1991].

1992-1993 онд дээрх шинжилгээний анги Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Хэрлэнбаян-Улаан, Цэнхэрмандал сумдын нутгаар хайгуул судалгааны ажил гүйцэтгэх явцдаа Хэрлэн Баян-Улаан уулын салбар Бугахайрхан, Их Хайлант, Шар хад зэрэг газраас палеолитын үеийн чулуун зэвсгийн зүйлс нэлээд хэмжээгээр цуглуулснаас [Гурван гол., 1992, 1993] гадна Дэлгэрхаан сумын нутаг Хэрлэн голын зүүн биенд орших Ханангийн энгэрийн палеолитын дурсгалт газрыг илрүүлсэн. Уг дурсгалт газраас илрүүлсэн үзүүр мэс, хусуур, хутга хэлбэрийн зэвсэг, ирлэсэн ялтас залтас, үлдэц зэргийг боловсруулан судалгааны эргэлтэнд оруулсан юм. Тэдгээрийн ерөнхий хэв шинж цуулалтын арга барилд үндэслэн дунд палеолитын сүүл үеэс дээд палеолитын дунд үед холбогдуулан үзсэн [Цогтбаатар, 1994] байна. Мөн тухайн бүс нутагт хамаарах Бугахайрхан уулын орчмоос түүвэрлэсэн 130 гаруй чулуун зэвсгийн олдворт боловсруулалт хийж мустьен үеэс дээд палеолитын дунд үед хамааруулан авч үзсэн байдаг [Цогтбаатар, 1998].

1993-1995 онд Монгол-Солонгосын хамтарсан “Дорнод Монгол” төслийн хээрийн шинжилгээний ангийн судлаачид Хэнтий аймгийн Цэнхэрмандал,

Сүхбаатар аймгийн Дарьганга сумдын нутгаар хайгуул болон туршилтын малтлага хийж, олон тооны чулуун зэвсэг илрүүлжээ [Монгол-Солонгосын., 3, 4].

1998 онд Монгол-Солонгосын хамтарсан “Монсол” төслийн хээрийн шинжилгээний анги Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Өглөгчийн голын эрэгт чулуун зэвсгийн малтлага судалгаа явуулж мянга гаруй олдвор илрүүлсэн байна

1998 онд Монгол-Францын хамтарсан экспедицийн судлаачид Тамсагбулагийн сууринд судалгааны ажил хийжээ. Малтлагыг 1967-1969 онд хийсэн малтлагын өмнөд ханыг үргэлжлүүлэн зүсэлт хийх маягаар үйлдсэн байна. Чулуун зэвсгийн олдвор бүхий хөрсний дээжийг Францын Радиоактивын лабораторид он цаг тогтоох судалгаа хийлгэсэн бөгөөд НТӨ 5.590 ± 120 (Gif-10949) мянган жилийн өмнөх үед холбогдох он цагийн хамаарлыг заажээ. Тиймээс тухайн дурсгалыг НТӨ VI мянган жилийн өмнөх үед холбогдуулан үзэх боломжтойг судлаачид тэмдэглэсэн байдаг [Гүнчинсүрэн, 2000: 9-14]

2003 онд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Хэрлэнгийн Хөдөө аралд хайгуул судалгаа явуулсан ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хээрийн шинжилгээний баг Ханзат, Бугахайрхан, Ханан зэрэг газруудаас олон тооны чулуун зэвсэг түүвэрлэсэн байна [Цогтбаатар нар, 2003].

2003 оноос Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын төвийн баруунтай орших Чандмань Хар уул орчимд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн баг археологийн авран хамгаалах судалгааны ажил хийж эхэлсэн. 2003 онд ажилласан хайгуулын баг шугаман хайгуулын аргаар тандалт хийсний үр дүнд газрын гадаргуу дээр тархсан 233 ш чулуун зэвсгийн олдворыг түүвэрлэн цуглуулсан байна. Дараа жил буюу 2004 онд хайгуул хийснээр нилээд олон газраас чулуун зэвсэг илрүүлж чулуун зэвсгийн суурингийн тоог 15 болгож, нийтдээ 2000 орчим чулуун зэвсгийн зүйлс түүвэрлэсэн байна. Түүвэрлэсэн чулуун зэвсгийн зүйлсийн дотор неолитын үед холбогдох олон тооны бичил хусуур, ялтас, цуулдас, үлдэц, цөөн тооны шөвөг, бифас маягийн зэвсгүүд, хоёр талаас нь холтчин зассан нарийн хицтэй сумны зэв 10 гаруйг илрүүлжээ [Амартүвшин нар, 2012: 15-18]

2004 онд Монгол-Японы хамтарсан “Шинэ зуун” төслийн хээрийн шинжилгээний ажлын явцад зарим судлаачид Хэрлэнгийн Хөдөө арал орчмын чулуун зэвсгийн дурсгалт газруудтай танилцаж 10 гаруй объектоос олон тооны чулуун зэвсгийн дээж цуглуулан анхан шатны боловсруулалт хийжээ. [Izuho et al., 2005].

Мөн Монгол-Японы хамтарсан “Палеолитын судалгаа” хээрийн шинжилгээний ангийн судалгааны хэсэг 2006 оны 09-р сард Хэнтий аймгийн

Дэлгэрхаан сумын нутаг Хэрлэнбаян-Улаан уулын Ханзат хэмээх газар хөрсөн дээрээ палеолитын дээд үеийн чулуун зэвсгийн баялаг дурсгалыг агуулсан сууринд соёлт давхарга байгаа эсэхийг тогтоох малтлагыг дөрвөн газарт явуулж нэгээс нь харьцангуй нимгэн боловч олон арван чулуун зэвсэг, амьтны ясны үлдэгдэл бүхий давхарга илрүүлэн олдворын нарийвчилсан судалгаа хийсэн байна [Izuho et al., 2007a].

2006-2008 онд Монгол–Японы хамтарсан “Палеолитын судалгаа” хээрийн шинжилгээний ангийн судалгааны хэсэг (Т.Цурумару, Б.Цогтбаатар, Я.Такаши, Г.Лхүндэв, Я.Шино, Ф.Мики) Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт орших Рашаан хад, Өглөгчийн голын эх орчимд хайгуул болон малтлага судалгааны ажил хийж гүйцэтгэсэн юм. Судлаачид хайгуул судалгаагаар илрүүлсэн олдворууд ерөнхийдөө неолитын үеийн шинж төрхийг агуулж байгаа боловч түүвэр олдворуудын дотор мезолитын үед холбогдох цөөн тооны эдлэл байгааг тэмдэглэсэн байна [Цогтбаатар нар, 2010: 32-51]

Дээрх судалгааны анги 2008 оны хайгуул судалгааны хүрээнд Батширээт сумын Улаан хадны хормойгоос чулуун зэвүүд болон түүнд холбогдох бэлдэц, цуулдас зэргийг илрүүлэн олжээ. Тэдгээрийг судалгааны эргэлтэнд оруулж холбогдох он цагийг шинэ чулуун зэвсгийн сүүл үе хүрэл зэвсгийн эхэн үед хамааруулан авч үзжээ. [Цогтбаатар нар, 2010: 52-60]

Монгол-Францын хамтарсан “Монголантропус” төслийн хүрээнд 2009 оноос эхлэн Хэнтий аймгийн Норовлин сумын нутаг Салхитын ам, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын нутаг Хавцгайт болон түүний эргэн тойронд буй чулуун зэвсгийн олдвор бүхий газруудад хайгуул, малтлага судалгаа хийж байна.

Монгол-Японы хамтарсан “Эртний монголчуудын палеоантропологиин судалгаа” төслийн хүрээнд Дорнод аймгийн Халхгол сумын нутаг Тамсагбулагт неолитын үеийн нүхэн сууц байж болохуйц газруудад малтлага судалгаа хийж байна [Цогтбаатар нар, 2012]

ШУА-ийн Археологийн хүрээлэн, Сөүлийн Их Сургуулийн Археологи, эртний урлалын тэнхимтэй хамтарсан хээрийн шинжилгээний анги 2011-2013 онуудад Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Рашаан хадны сууринд малтлага судалгаа хийжээ. Малтлагаас илэрсэн зэрлэг адууны яс 35630 ± 180 (IAAA-110745; 41340~40353 calBP at 95.4%), болон үхрийн яс 35070 ± 180 (IAAA-110746; 40905~39436 calBP at 95.4%)-нд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнд тухайн дурсгал дээд палеолитын эхэн үед холбогдохыг харуулж байна [Гүнчинсүрэн нар, 2012].

Монгол орны хээрийн бүс нутгийн палеолитын үеийн нэгэн сонирхолтой дурсгал бол Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг Ачаат уулын суурин юм. Уг дурсгалыг МУИС-ийн оюутны хээрийн дадлага ажлын үеэр анх илрүүлсэн бөгөөд 2012 онд ШУА-ын Археологийн хүрээлэнгийн судлаачид чулуун зэвсгийн олдворуудын тархалтын хүрээг урьдчилсан байдлаар тодорхойлж, олдворуудын түүвэр цуглуулга хийжээ. Судлаачид тухайн дурсгалын чулуун зэвсэг үйлдвэрлэлийн хэв маяг, олдворуудын төрөл зүйлд үндэслэн мустьен сүүл үеэс дээд палеолитын эхэн үед холбогдуулан үзсэн байна [Цогтбаатар, Пүрэвжал, 2014: 15-24].

Ачаат уулын орчимд Устай Бургастайн Барга элсний неолитын сууринд МУИС-иас зохион байгуулсан “Дорнод Монгол” төслийн хүрээнд 2008, 2009, 2011 онуудад ажиллаж олон тооны чулуун зэвсгийн зүйлс цуглуулсан байдаг [Цыденова и др., 2012].

Монгол орны зүүн бүс нутагт хийсэн чулуун зэвсгийн судалгааны эхэн үе буюу 1930-1960-аад онуудад ихэвчлэн мэдээ шалгах, цөөн тооны олдвор түүвэрлэх маягаар цаашдын судалгааны үндэс суурийг боловсруулжээ. Харин 1960-аад оноос МЗТСХЭ-ийн Чулуун зэвсэг судлах анги Зүүн Монголын бүс нутагт өргөн цар хүрээтэй хайгуул судалгаа хийсэн бөгөөд судалгааны үр дүнд илрүүлсэн ихэнх дурсгалууд шинэ чулуун зэвсгийн үед холбогдож байв. Мөн шинэ чулуун зэвсгийн үеийн нүхэн сууц, оршуулгуудыг илрүүлэн судалсан байна. Сүүлийн жилүүдэд Солонгос, Япон, Америкийн судлаачидтай хамтарсан төсөл, хөтөлбөрийн хүрээнд палеолит болон неолитын дурсгалуудын судалгаа, палеолитоос мезолит, неолитоос төмөрлөг зэвсэгт шилжсэн шилжилтийн үеийн түүхийн асуудлуудыг тодруулах зорилготой судалгааны ажлууд хийгдэж байна.


2. ЗАРАА УУЛ ОРЧМЫН ГАЗАРЗҮЙН БАЙРЛАЛ

Хамтарсан төслийн хүрээнд малтлага судалгаа хийсэн Зараа уул нь гадаргын хэв шинжийн хувьд Монголын дорнод их мужийн Баяндэлгэрийн дэд мужид хамаарна [Монгол улсын..., 2009: 66-67]. Монголын Дорнодын их мужид уул нурууд бараг байхгүй, голчлон ухаа гүвээт талын байдал зонхилдог. Энэ нутаг баруун хойд этгээддээ Хангай-Хэнтийн уулархаг их мужийн зүүн хагастай хил залгаж хойд ба зүүн зах нь улсын хилээр зааглагдана. Ганцхан түүний урд хил төдий л тодорхойгүй боловч ландшафтын нийт төрх байдлыг харваас уг хилийг зүүнээс баруун тийш Сүхбаатар аймгийн Наран сум хавиас эхэлж баруун хойш Чойр хүрч тэндээс барагцаалан баруун тийшээ Мандал Говийн хойгуур оруулан Дундговь аймгийн Эрдэнэдалай хүртэл оруулж болно. Ийм хил заагтай ийнхүү нутагт тус улсын засаг захиргааны гол нэгжүүдээс Дорнод, Сүхбаатар аймгууд бараг бүтнээрээ багтахгаас гадна Хэнтий, Төв аймгуудын урд хэсэг, Дундговь, Дорноговь аймгуудын хойт хэсэг тус тус хамаарна. Бүх нутгийн нь хэмжээ 247630 хавтгай дөрвөлжин километр орчим юм.

Тус их мужийн гадарга уулархаг их мужийнхтай адил сүүлийн үеийн уул тогтох хөдөлгөөнөөр өндөрт өргөгдөөгүй, анх төрмөлийн эриний сүүл үед тавцангийн байдалд шилжсэн тэр цагаас хойш харьцангуй нам байдалтай үргэлжилсээр иржээ. Уулсын үнэмлэхүй өндөр 1400-1800 метр орчим, харин харьцах өндөр нь тун ялимгүй, хамгийн ихдээ 400-500 метрээс үл хэтэрнэ. Энэ уул толгод ганц нэгээрээ буюу далан, сэрвэн үүсгэж цувран оршино. Хотгор хонхрууд янз бүрийн дүрс хэлбэртэй, хэмжээ нь ч харилцан адилгүй. Монголын дорнод талын зүүн захад Их Хянганы салбар уул орших тул тэр хэсэг ландшафтын төрх байдлаар огт өөр юм. Тэнд налуувтар хажуутай, бөмбөгөр, эсвэл хавтгай оройтой бэсрэг уулс зонхилж голын хөндийнүүд голдуу нарийн бөгөөд харьцангуй гүн байдаг. Орчин үед энд байнгын урсгалтай гол горхи ховор боловч дээр үед усны ажиллагаа нилээн идэвхтэй байсныг гэрчлэх ор мөр цөөнгүй бий.

Зараа уул Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт, сумын төвөөс зүүн урд зүгт 10 км орчим зайд оршно. Уул зүүн хойноос баруун урагш чиглэн 2.5 км урт зайд сунаж тогтсон бөгөөд зүүн хойд талаасаа баруун урагшаа аажим намсжээ. Зараа уулын дунд хэсэгт нь байх ноёлог өндөр далайн түвшнээс дээш 1104 м өндөртэй. Уул боржин хадан тогтоцтой бөгөөд өвөр биед нь Өгөөмөрийн говь хэмээх өргөн хотос хөндий бий. Энэхүү өргөн хөндийн баруун зах тунамал чулуулаг болон хүрмэн хад чулуугаар хүрээлэгдсэн бол хөндийн шал нь нэлэнхийдээ

плейстоцены үеийн шохойлог хөрсөнд хучигдсан байна. Энэ хөндий эрт цагт давслаг ихтэй нуурын ёроол байсан байсан нь лавтай юм. Харин өнөөдөр энэхүү шохойлог хөрс бүхий газарт олон мянган жил үргэлжилсэн байнгын болон тур зуурын урсац усны нөлөөгөөр олон жижиг дов довцог, хошуу үүсжээ. Өнөөгийн байдлаар нэг жижиг гадаргын урсац буюу тухайн бүс нутгийн мал амьтан ундаалдаг шанд мэдэгдээд байна. Тухайн орчны бусад уулаас ялгагдах гол онцлог нь Зараа уул хад асга ихтэй бөгөөд ноёлог өндрийн урд талаар цавчим хавцлуудтай, өвөр талаараа нөмөр дулаан мухар амууд, сайраар хэрчигдсэн байдалтай юм. Мөн эрт үед тухайн бүс нутаг ус голоор элбэг байсныг илтгэх хуурай сайрууд олон бий. Тэдгээрийн хамгийн том нь уулын зүүн хойд талаар ороон өвөр биеэр нь өнгөрөх эртний голын сав юм. Энэхүү сайр Зараа уулын өвөр бие рүү буусан олон хуурай сайрын усаар тэжээгдэн Өгөөмөрийн Улаан хэмээх том нуурын савд цутгадаг ажээ. Бороо орсны дараа эдгээр сайруудаар гол урсах ба эрэг хөвөөгөөр нь мод ургасан байгаа нь хөрсний ус гадаргад ойрхон байдгийг гэрчилнэ. Мөн уулын өвөр биед ус тогтох нуурын хонхор олон бий. Энэ бүхнээс үзэхэд, Зараа уул орчмын нутаг эрт үед гол ус, нуур элбэгтэй, зөөлөн уур амьсгал бүхий газар байсан бололтой.



Зураг-1. Зараа уулын топографийн зураг

Хөндийн зүүн хэсэгт мөн шохойлог тойром мэдэгдэх ба хур тунадасны хэмжээнээс шалтгаалж дээр нь нуур тогтдог аж.

Зараа уулын орчимд өмнөх оршиж байсан нуурын бага зэрэг налуу болоод зарим хэсэгтээ хошуурч өргөгдсөн хавтгай оройтой дэнж хэд хэд ажиглагдав. Эдгээр дэнжийн өндөр нь далайн түвшнээс дээш 1043 м оршино. Эндээс дунд болон дээд палеолитынн эхэн үед хамаарч болох чулуун зэвсгийн олдворууд түүвэр байдлаар илэрсэн. Ажиглалтын хуучин чулуун зэвсгийн олдворууд цагаан шаргал өнгийн эрт үеийн нуурын эрэгт тохиолдох элсэрхэг хөрсөнд хадгалагдаж буй нь тодорхой байна. Чулуун зэвсгийн олдворууд плейстоцены сүүл үед энэхүү хөндийг нэлэнхүйд нь дүүргэж байсан нуурын эргийн хязгаарыг харуулж байх магадлалтай юм. Харин 13500 -11700 жилийн өмнө болсон цаг уурын хувирамтгай байдал буюу гэнэтийн дулаарал, хүйтрэлээс үүдэн тус нуурын ус хурдацтай татарсан нь сорьц малтлага болон өрөмдлөгийн үеэр мэдэгдлээ.

Одоогоос 8000-4000 жилийн тэртээд (дунд голоцене) Ази тивд чийглэг дулаан уур амьсгал эргэн тогтсон байдаг. Монголын дорнод хэсгийн говь, хээрийн бүс дундад азийн борооны улирлаас нэлээд зайтай боловч тодорхой хэмжээний хур тунадас унадаг байсан нь эртний байгаль орчны мэдээнээс тодорхой харагдаж байна. Зараа уулын орчимд дунд голоцений үед хур тунадас их унаж хөрсний хурдасжилт эрчимтэй явагдаж байжээ.

Ихээр орох болсон борооны улмаас түр болон байнгын урсгалтай олон гол горхи үүсэж орчны гадаргын тогтоцод багагүй өөрчлөлт орсон юм. Эдгээр урсац усаар тэтгэгдэг цэвэр усны тогтоц үүссэн болохыг шохойлог хөрсний дээр тогтсон органик материалаар баялаг шаварлаг үе тодорхойлно. Мөн тус үед агуулагдах кальцийн карбонат (CaCO_3)-ын жижиг бөөгнөрөөс харахад, эдгээр нуурууд зарим улиралд хатаж байжээ.

Харин голоцений сүүл үед цаг уурын өөр нэг томоохон өөрчлөлт гарсан нь одоог хүртэл үргэлжилж байх магадлалтай. Энэ нь плейстоцены үеийн гадаргын хөрсөн дээр тогтсон 15-20 см зузаан бор өнгийн бүдүүн ширхэгтэй хөрснөөс тодорхой харагдана. Харин голоцены сүүл үед хамаарах нь ердөө хөрсний дээд давхаргад буй 3-5 см зузаан хөрс юм. Үер ус, салхины нөлөөгөөр зөөгдөх шороо, чулуу зэрэг нь тус дурсгалт газрын бүрэн бүтэн байдалд сөргөөр нөлөөлсөн нь харагдаж байна.

3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Монгол орны говь, хээрийн бүс нутгийн чулуун зэвсгийн дурсгалт газрууд ихэвчлэн хөрсөн дээр үе үеийн олдворуудыг агуулсан ил суурин хэлбэрээр оршдог билээ. Тиймээс юуны өмнө олдворуудын нягтшил, тархалтын хүрээ заагийг тодорхойлох нь чухал юм.

Зараа уулын чулуун зэвсгийн олдворуудын тархалтын хүрээ, зааг, нагтшилыг тодорхойлохдоо өнгийн туг ашигласан бөгөөд олдворуудын нягтшил их, төрөл зүйл олон байсан тул зөвхөн зэвсгийн чанартай хоёрдогч боловсруулалт хийгдсэн эдлэлүүд, анхдагч цуулалтыг тодорхойлох олдворууд болон онцлох цуулдасуудын дэргэд туг хатгаж тэмдэглэсэн болно. Ингэснээр олдворууд хоорондоо тодорхой зайд буюу хэсэг хэсэг газарт байрласан олдворуудын бөөгнөрлийг харах боломжтой билээ. Мөн энд нэг анхаарах зүйл бол чулуун зэвсгийн олдвор тархсан гадаргуугийн байршил зүй, гадаргын хэв шинж, хөрсжилт билээ.

Чулуун зэвсгийн олдворууд хөрсөнд дарагдах, налуу даган гулсах болон усны үйл ажиллагааны нөлөөгөөр зөөгдсөн байдгийг тооцоолох хэрэгтэй юм. Олдворууд тархсан байршлуудыг туг хатгаж тодорхойлсны дараа гэрэл зурган баримтжуулалт хийнэ. Мөн тухайн дурсгалуудын байршил зүйн ерөнхий план зургийг гаргана. Үүний дараа тухайн дурсгалт газарт соёлт давхарга байгаа эсэхийг тодорхойлох анхан шатны оролдлого хийнэ. Энэ нь хүрзэн шалгалт болон гар өрмийн тусламжтайгаар хийгдэх ба олдворууд тархсан гадаргуугийн байршил зүйг харгалзан үзнэ. Гар өрмөн шалгалт хийх цэгүүд нь хоорондоо 2-4 м зайтай байх ба өрмөөс гарсан бүх шороог шигшүүрээр шигшүүрдэж илэрсэн олдворыг өрмийн цэгийн дугаар болон гүний хамт тэмдэглэнэ. Энэ нь сорилын малтлага, цаашлаад өргөн хэмжээтэй малтлага хийх газрыг тодорхойлоход дөхөм болно. Өрмөн шалгалтын үр дүнгээс хамааран 50 x 50 см хэмжээтэй талбайд хүрзэн шалгалт хийх эсэхийг шийднэ. Хүрзэн шалгалт нь өрмөн шалгалтын мэдээг баталгаажуулах нэг хэлбэр юм.

Өрмөн болон хүрзэн шалгалтын үр дүнд хөрсний хурдас хуримтлагдаж соёлт давхарга үүссэн байх боломжит газруудыг тодорхойлсны дараа судалгааны дараагийн шат болох малтлага судалгааг хийнэ. Чулуун зэвсгийн дурсгалт газрын судалгаанд *сорилын болон өргөн хэмжээний малтлагын* арга зүйг ашигладаг.

Сорилын малтлагыг 2 м² – 4 м² талбайд гүйцэтгэх ба тухайн газрын налуу, ургамалжилт зэргээс шалтгаалан чиглэлийг тодорхойлно. Малтлагыг археологийн шинжлэх ухааны малтлагын үндсэн арга зүйн дагуу хийж, гэрэл болон гар зургийн

баримтжуулалт, түвшингийн тэмдэглэгээ, малтлагын тодорхойлолт, дээж авах зэргийг шаардлагад нийцүүлэн хийнэ.

4. ХАЙГУУЛ СУДАЛГАА

Уур амьсгалын эрс, тэс нөхцөл байдлаас шалтгаалан тус орны говь, хээрийн бүс нутгийн ихэнх чулуун зэвсгийн дурсгалууд газар дээр олдворуудыг агуулсан ил суурин хэлбэрээр оршдог хэдий ч өмнөх жилүүдэд Зараа ууланд хийсэн судалгаа тухайн бүс нутгаас соёлт давхаргатай дурсгалт газрууд илрэх магадлалтайг харуулсан билээ. Тиймээс судалгааны шинэ эх хэрэглэгдэхүүн бий болгох зорилготой цөөн хоногийн хайгуул судалгааг Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Онгон, Наран, Дарьганга сумдын нутагт хийж гүйцэтгэлээ. Хайгуул судалгааны үр дүнд Баяндэлгэр сумын нутаг Онгон элсний Баруун булаг, Адуун худаг, Онгон сумын Энгэр шар бүрд, Хөндлөнгийн гол зэрэг газруудад чулуун зэвсгийн олдворт газруудыг шинээр илрүүлсэн бөгөөд тус төслийн судлаачид 2013 онд Монгол-Америкийн хамтарсан “Дорнод Монгол: археологийн хайгуул судалгаа” төслийн багт оролцон ажиллахдаа илрүүлсэн Өлзийн булаг, Салаа булагийн суурингуудад сорьц малтлага хийж гүйцэтгэлээ.

Баруун булагийн чулуун зэвсгийн суурин, булш. Хайгуул судалгааны явцад Онгон элсний баруун хаяанаас эх авч урсах Баруун булаг орчмын нутаг чулуун зэвсгийн бууц суурин, эртний нүүдэлчдийн булш оршуулгын дурсгал бүхий ихээхэн сонирхолтой газар гэдэг нь тогтоогдсон.



Зураг-2. Баруун булагийн чулуун зэвсгийн олдворт газар болон дараасгүй булш

Баруун булагийн орчим чулуун зэвсгийн олдворууд өнгөн хэсгийн элс салхины нөлөө болон гадаргуугийн налуу дагаж гулссан хэсгүүдээр ил гарсан хар бараан өнгийн хатуу шаварлаг давхаргын дээд талаас ганц нэгээр тааралдах

бөгөөд харин булгийн эхэн хавьд нэлээд шигүү тархжээ. Энд анхны ажиглалтаар гол төлөв жижиг ялтас, цуулалтын явцад бий болсон хагархай, хэлтэрхий, залтас тархсан байна. Мөн Хятаны үед холбогдуулан үзэж болох хээ чимэглэл бүхий ваарны хагархай нэлээд олдож байв.

Чулуун зэвсгийн олдвор тархсан энэ хэсгээс төдий л холгүй элсэн дундаас ганц жижиг хад цухуйж харагдсан бөгөөд эргэн тойрон чулуун зэвсгийн олдвор нэлээд байх тул гал голомтны үлдэл байж магадгүй хэмээн өнгөн хөрсийг цэвэрлэж үзэхэд, шатсан, гал түлсэн ором гарсан төдийгүй чулууны зүүн талаас хүний толгойн ясны оройн хэсэг илэрсэн. Цааш нь цэвэрлэх явцад толгойгоор нь баруун хойд зүгт хандуулан, нүүрийг нь зүүн зүгт ялимгүй жишүүдүү харуулан тавьсан бүтэн оршуулга илрэв (зураг 3). Хүний яс хөндөгдөөгүй анхны тавилтаараа бөгөөд цээжин талыг нь ялимгүй өндийлгсөн тул толгой талаас нь анх цэвэрлэхэд суугаа мэт сэтгэгдэл төрүүлж байв. Хоёр гарыг биеийг нь дагуулан тохойгоор нь ялимгүй нугалж ташаан дээр нь тавьжээ.



Зураг-3. Баруун булагаас илрүүлсэн дараасгүй булш

Оршуулгын зүүн өвдөгний хажуугаас буюу өнгөн хөрснөөс доош 40 см гүнээс ваарны хагархай 13 ш, аарцагны ясны доороос ногоон өнгийн чулуугаар хийсэн, голдоо нэвт нүхтэй, цилиндр хэлбэрийн сувс 1 ш гарлаа (зураг 4-3). Ваарны хагархай бүгд жижиг хэмжээтэй бөгөөд амсарын хэлтэрхий (4 ш) (зураг 4-1-3)-д үндэслэвэл босоодуу амсартай сав байсан бололтой. Амсрын доод талаар зэрэгцээ зууван хэлбэрийн хонхор гаргаж чимэглэсэн бөгөөд харин их бие хэсгийн хагархайнууд хээ чимэглэлгүй ажээ.



Зураг-4. Баруун булагаас илрүүлсэн дараасгүй булшны олдворууд



Зураг-5. Баруун булагаас илрүүлсэн дараасгүй булшны олдворууд



Оршуулгын толгой талд, баруун шанаанд нь тулган ганц ширхэг жижиг хад тавьсан нь газрын өнгөн хөрсөн дээр цухуйж байжээ. Энэ хүнийг ялимгүй хонхойлгосон гүехэн нүх малтаж оршуулсан бололтой. Оршуулгын толгой болон хөл талаас шатсан модны нүүрс илэрсэн нь зан үйлийн улбаа бололтой.

Ваарны хагархайнууд харьцангуй жижиг хэмжээтэй тул ямар хэлбэртэй сав байсныг тодорхойлох боломжгүй юм. Харин оршуулгаас илрүүлсэн цайвар ногоон өнгийн цилиндр хэлбэрийн сувстай ижилсэх эдлэл Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Булан тойромын булшнаас гарсан байх бөгөөд судлаачид C^{14} насжилт болон булшнаас илэрсэн эд өлгийн зүйлүүдэд тулгуурлан Сяньбигийн үед хамаарч магадгүй хэмээн таамагласан байна¹.

Баруун булаг, Булан тойромын булшнуудад нас барагчийн оршуулсан байдал, зарим олдвор (зүүлт), шороон дараас зэрэг хоорондоо адилсах шинж тэмдгүүд ажиглагдаж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Баруун булагийн орчимд гүехэн нүхэнд хүнээ оршуулсан шороон дараастай булш оршуулгын дурсгалын нэгэн хэлбэр байх магадлалтай байна. Булагийн салаа хэмээх Баруун булагийн урд орших гүн жалганы зүүн талын гүвээний орой хэсэгт, хөрсний элэгдлээр ил гарч устсан өөр нэг булш илрүүлсэн бөгөөд юуных нь тодорхойгүй үжирч муудсан ясны хэлтэрхийнүүд, шавар ваарны хагархайнууд элсний хагарлаар тархсан байв.

Энд өмнө малтсан булшнаас гарсантай төстэй дээд хэсгээрээс ялимгүй дэрэвгэр босоодуу амсартай, амсрын доод талаар зэрэгцээ зууван хонхор гаргаж

¹ Ч.Амаргүвшин, О.Батзориг. Булан тойромын булш // Археологийн судлал, Том. XXXV, fasc. 24. УБ., 2015. т.372-379

хээлсэн ваарны хагархай (зураг 5-2), дээрээ зэрэгцээ ташуу зураасууд бүхий товгор наамал хээгээр чимэглэсэн зузаан ханатай ваарны хагархай (зураг 5-3), шатаалт сайтай, нимгэн, гадна талдаа босоо богино зураасуудыг хөндлөн эгнээнд сөөлжүүлэн байрлуулсан чимэглэл бүхий ваарны хагархайнууд илэрч олдсон байна (зураг 5-1).



Зураг-6. Баруун булагт ил хөрсний элэгдлээр ил гарч устсан булш ба газардээр тархсан ваарны хагархайнууд

Малтлага судалгаа хийсэн булшны дээжинд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүн эндэхийн дараасгүй, гүехэн нүхэнд оршуулсан булш оршуулгуудын хамаарах он цагийн асуудал, Монголын өмнөд хэсэг Булан тойромын булштай адилсах эсэхэд хариулт өгнө хэмээн найдаж байна.

Адуун худагийн суурин. Онгон элсний баруун урд үзүүрт, зүүнээс баруун урсах жижиг булгийг нутгийн олон Адуун худаг хэмээн нэрийднэ. Булгийн эхэн хавьд неогений үеийн улаан өнгийн хурдас ил гарсан хотгорын зүүн талын дэнжийн оройгоос палеоит болон неолитын хэв шинж бүхий олдворууд сийрэг тархсан

дурсгалт газар илрүүлээ. Олдворууд сийрэг тархсан байсан бөгөөд бид сонголтын зарчмаар 3 ш олдвор түүвэрлэлээ. Эдгээр нь жижиг ялтас цуулан авсан ул мөрийг цуулалтын гадаргуудаа хадгалсан шаантган үлдэц, тэгш өнцөгт маягийн хэлбэртэй, нэг хажууг хоёр талаас нь хурцлан зассан шаантган маягийн үлдэц болон техникийн цуулдас юм.



Зураг-7. Адуун худагийн чулуун зэвсгийн олдворт газар

Энгэр шар бүрдийн чулуун зэвсгийн суурин. Сүхбаатар аймгийн Оногн сумын төвөөс зүүн урагш шулуунаар 35 км зайд, өргөн хотос говийн зүүн хэсэгт орших тогтоол устай жижиг нуурыг нутгийн иргэд Энгэр шар бүрд хэмээн нэрийддэг. Энэ нь говь цөлийн бүс нутагт хааяа тааралдах баян бүрд бөгөөд, эртний том нуурын үлдэл ажээ. Бид Энгэр бүрдийн орчимд хайгуул хийхэд шинэ чулуун зэвсгийн хэв шинж бүхий олдворууд ганц нэгээр тааралдаж байлаа. Чулуун зэвсгийн олдворууд нуурын арын дэрстэй товцгууд болон уул уруудсан гүн жалганы эрэг ирмэг дагуу голоцены үеийн шаварлаг хар хөрстэй давхаргын дагууд илүү нягт тархсан байна.

Эндээс нийт 18 ш чулуун зэвсгийн олдвор түүвэрлэн цуглуулсан. Түүвэр олдворуудын дунд жижиг ялтас цуулсан ул мөртэй шаантган үлдэц (4 ш), бүх ирмэгийн дагууд цуулалт хийсэн шовх үлдцийн дээд хэсэг, хоёр талас нь холүтчин ирлэсэн бифас хэлбэрийн зэвсгийн хугархай, хатгуур, хусуур (2 ш), залтас (5 ш), хагархай (4 ш) тус тус байна. Мөн гадаргуудаа ямар нэг хээ чимэггүй ваарны хагархай 4 ш олджээ.



Зураг-8. Энгэр шар бүрдийн чулуун зэвсгийн суурин

Хөндлөнгийн голын шинэ чулуун зэвсгийн дурсгалт газар. Энгэр бүрдийн зүүн талд, өргөн хотос говийн зүүн талаас орж ирэх эртний голын сав том хуурай сайрыг тийнхүү нэрийддэг. Энэхүү хуурай сайрын урд талын дэнжийн налуугийн гурван газраас шинэ чулуун зэвсгийн хэв шинж бүхий олдворууд илрүүлсэн.



Зураг-9. Хөндлөнгийн голын чулуун зэвсгийн олдворт газруудын тэмдэглэгээ

Эндээс бичил ялтас цуулсан ул мөртэй үлдэц (6 ш), залтсаар хийсэн хусуур (3 ш), жижиг ялтасны үзүүрийг хурцлан зассан цоолтуур, дугуй хэлбэртэй том залтасны нэг хажуу ирмэгийг налуулан хайрслан ирлэсэн хянгар болон жижиг ялтас болон ялтасны хугархай (7 ш), залтас, цуулдас хагархай хэлтэрхий (20 ш), ваарны хагархай (14 ш) буюу нийт 52 ш олдвор газар дээрээс түүвэрлэн цуглуулсан. Ваар савны хагархай нь улбар болон сааралдуу өнгөтэй бөгөөд хээ чимэглэлгүй. Нэг жижиг хагархай нэвт нүхэлсэн ором мэдэгдэнэ.

Дуут нуурын суурин. Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг, Алтан овооны баруун талд орших жижиг нуурыг Дуут нуур хэмээнэ. Энэхүү суурийнг урьд

нь МЗТСХЭ-ийн судлаачид илрүүлсэн бөгөөд бид хайгуулын ажлын явцад дахин баримтжуулсан юм.

Дуут нуур-1. Нуурын баруун хойд эрэгт орших чулуун зэвсгийн олдвор тархсан талбар бөгөөд эндээс нийт 41 ш чулуун зэвсгийн олдвор, 23 ш ваарны хагархай газар дээрээс түүвэрлэн цуглуулсан. Тэдгээр нь бичил ялтас цуулах зориулалт бүхий үлдэц болон бэлдэц (8 ш), ооль, хусуур, ир гаргасан хагархай, самбар чулууны хагархай (2 ш), дугуй хэлбэрийн үрүүл, цуулдасны үйлдвэрлэлд хамаарах залтас, ялтас, хагархай, хэлтэрхий (29 ш), ваарны жижиг хагархай хэмээн ангилагдана.

Дуут нуур-2. Дуут нуурын баруун хойд талын намхан эргийн налуу болон дээрээс 49 ш чулуун зэвсгийн олдвор газрын хөрсөн дээрээс түүвэрлэсэн бөгөөд жижиг ялтас цуулах зориулалт бүхий үлдэц, зүлгэж зассан оолийн үзүр хэсгийн хугархай, цуулдасны үйлдвэрлэлд хамаарах 47 ш эдлэл хэмээн ангилагдана.


Өлзийн булагт хийсэн сорьц малтлага. Молцог элсний баруун хойд хаяанаас эх авч урсан тунгалаг уст булгийг нутгийн ардууд Өлзийн булаг хэмээн нэрийдэх бөгөөд бид 2013 оны хээрийн судалгааны явцад энэ орчимд чулуун зэвсгийн олдворууд тархсан дурсгал байгааг тогтоосон. Энэ онд бид соёлт давхаргатай эсэхийг тогтоох зорилгоор сорьц малтлага хийлээ.



Зураг-10. Өлзийн булаг ба сорьц малтлагууд

Эхний малтлагыг булгийн зүүн хойд талын намхан дэнжийн орой дээр хийхэд ямар нэг олдвор, эд өлгийн зүйл гаралгүй 80 см гүнд хүрсэн бөгөөд ямар нэгэн олдвор, эд өлгийн зүйл илрээгүй тул малтлагыг зогсоосон. Дараагийн сорьц малтлагыг дэнжийн хормойн элсэн товцгийн орчимд хийсэн бөгөөд олдвор, эд булгийн зүйл гаралгүй 70 см гүнд хүрсэн тул малтлагыг зогсоов. Малтлагын ханын зүсэлтэнд хар бараан өнгийн ялзмаг хөрс болон шаварлагдуу давхарга үелэн илэрсэн нь эртний уур амьсгалын өөрчлөлтийг харуулж байх магадлалтай юм.

Салаа булагийн орчимд хийсэн сорьц малтлага. Харин Салаа булагт хийсэн судалгаа нэлээд сонирхолтой үр дүнг харуулсан. Салаа булаг бол Молцог элсний ар биеэс ундрах цэнгэг, хүйтэн уст булаг билээ. Эндээс чулуун зэвсгийн олдвор, ваарны хагархай бүхий 4 газар илрүүлсэн бөгөөд Салаа булаг-1, 1b, 2, 3 хэмээн дугаарлаж тэмдэглэсэн (зураг 11).



Зураг-11. Салаа булагийн чулуун зэвсгийн олдворт газруудын тэмдэглэгээ

Малтлага судалгааг Салаа булаг 1b хэмээн тэмдэглэгдсэн талбарт хийж гүйцэтгэлээ. Энэ нь булгийн эхний зүүн орой дээр, баруун тийш харсан элсэн товцогийн налуу юм. Энд чулуун зэвсгийн олдворууд маш шигүү тархсан байсан тул хөрсний элэгдлээр ил гарсан неолитын үеийнх байж мэдэхээр бараан өнгийн шаварлаг хөрсийг дайруулан 100 x 300 см хэмжээтэй талбайд малтлага хийлээ. Малтлагын явцад 20 см орчим зузаан элсэн хөрсөн доороос 35 см зузаан хар бараан өнгийн шаварлаг давхарга илэрсэн бөгөөд чулуун зэвсгийн олдвор, ваарны хагархай, амьтны ясны хэлтэрхий олон гарч байв. Хар бараан өнгийн шаварлаг давхаргын доод талаас элсэрхэг хөрс илэрсэн нь ямар нэг олдвор, эд өлгийн зүйл агуулаагүй болох нь 80 см орчим гүн малтахад тодорхой болсон юм. Чулуун зэвсгийн олдворуудын дунд жижиг болон бичил ялтас цуулан авах зориулалт бүхий үлдцүүд (зураг 13-3, 7), хусуурууд, хоёр талаас нь жигд нямбай холтчин бэлтгэсэн

нимгэн бифас (зураг 13-8) олон гарсны зэрэгцээ шинэ чулуун зэвсгийн хожуу үед холбогдох боломжтой хоёр талт зэвүүд хэд хэд илрэв (зураг 13-1, 2, 4). Мөн зэвсгийн цуглуулгын дотор ирлэсэн ялтас (зураг 13-5), залтас (зураг 13-6) олон байна.




Зураг-12. Салаа булагт хийсэн сорьц малтлага

Сорьц малтлагын үр дүнд Салаа булагийн суурингийн он цагийг лабораторийн судалгаагаар тодорхойлох боломжтой хэрэглэгдэхүүнийг бий болгосон бөгөөд цаашид судалгаа хийхэд ихээхэн ирээдүйтэй газар болохыг тогтоосон юм.

Хайгуул судалгааны явцад мөн булш оршуулгын дурсгалуудын бүртгэлийг хийсэн. Баяндэлгэр сумын Хужирын гол, Наран сумын Хөндлөнгийн гол, Онгон сумын баруун урдах өргөн хөндийн зүүн хэсэг, Дарьганга сумын Салаа булагийн адаг,

Алтан овооны баруун хойд талаас ганц нэгээр болон бүлэг булш оршуулгын дурсгалуудыг баримтжуулан тэмдэглэсэн юм.

Хайгуул судалгааны үр дүнд хэд хэдэн шинэ дурсгалыг илрүүлсэн бөгөөд Салаа булагийн сууринд цаашид илүү өргөн хүрээнд малтлага судалгаа хийх боломжтойг тогтоолоо. Мөн хайгуулаар илрүүлсэн чулуун зэвсгийн олдворт газрууд эртний гол, нуурын сав газар, одоо ч ундарсаар байгаа булаг шандны ойр орчимд тархсан байрлал зүйн нийтлэг байдал ажиглагдаж байв.




Зураг-13. Салаа булагт хийсэн малтлагаас илрүүлсэн зарим чулуун зэвсгүүд. Зэв-1, 2, 4; үлдэц-3, 7; ирлэсэн ялтас-5, ирлэсэн залтас-6; зуулга-8

5. МАЛТЛАГА СУДАЛГАА

6.

5.1 Чулуун зэвсгийн дурсгалын малтлага

Зараа уулын Ил энгэрийн 2-р дурсгалт газарт малтлага судалгааг үргэлжлүүлэн гүйцэтгэсэн. Энд өмнөх жилийн малтлагын хойд талд нийт 12 м² талбай сонгон малтлага судалгааг хийв. Хөрсний давхарга зүйн хувьд өмнөх жилийнхээс онцын өөрчлөлтгүй ажээ.



Зураг-14. Зараа уулын археологийн дурсгалын байршил

Хөрсний давхаргууд хоорондоо нэлээд холилдсон байдалтай бөгөөд кальцийн карбонат агуулсан цайвар өнгөтэй шаврын бөөгнөрөл үүнийг давхар гэрчилж байна. Хэдийгээр хөрсний үе давхаргын бүтэц алдагдаж, хоорондоо нэлээд холилдсон шинжтэй боловч бид чулууны агууламжинд тулгуурлан 3-аас 4 өөр төлийн хөрснөөс бүрэлдсэнийг тогтоосон.

Чулуун зэвсгийн олдворууд, ваарны хэлтэрхий, амьтны ясны хэсгүүд хөрсний 1 болон 2-р давхаргаас хамгийн ихээр илэрсэн. 2-р давхаргын доод зааг нь өнгөн хөрснөөс доош 20-55 см гүнд цайвар өнгийн кальцийн карбонат ихтэй шаварлаг хөрсний үетэй нийлж байна. Хөрсний 3-р үе 20-30 см орчим зузаантай. Чулуун

зэвсгийн олдворууд өмнөх үеүдтэй харьцуулахад 3-р давхаргаас цөөн илэрсэн. Малтлага өнгөн хөрснөөс доош 90 см гүнд хүрэхэд чулуун зэвсгийн олдворууд харьцангуй багассан бөгөөд амьтны яс, ваарны хагархай гараагүй нь он цагийн хувьд нэлээд эрт үед холбогдохыг харуулж байна. Хөрсний 3-р үеийн доороос маш хатуу шаварлаг хөрс (зарим хэсэгтээ ногоон өнгөтэй) гарсан нь плейстоцены үеийн нуурын ёроол бололтой. Хүрзэн шалгалтыг хоёр хэсэг газарт хийхэд өнгөн хөрснөөс доош 110 см гүнээс цөөн тооны чулуун зэвсгийн олдвор илэрсэн нь ихээхэн сонирхолтой юм. Чулуун зэвсгийн олдворууд ганц нэгээр гарч байсан тул малтлагыг цаашид үргэлжлүүлэхэд өнгөн хөрснөөс доош 150 см гүнд, хатуу шаварлаг давхаргаас чулуун зэвсгийн олдвор гарсан юм. Олдвор илэрсэн гүнийг харгалзан үзвэл, энэ нь нэлээд эрт үед холбогдох магадлалтай бөгөөд дараагийн судалгааны явцад илүү нарийвчлан үзэх, энэхүү давхаргын он цагийг тогтоох эх хэрэглэгдэхүүн олох шаардлагатай болж байна.



Зураг-15. Зараа уулын Ил энгэрийн 2-р суурин

Хүрзэн шалгалт болон гар өрмийн мэдээлэлд тулгуурлан дараагийн малтлагыг Зараа уулын Ил энгэрийн 3-р дурсгалт газарт хийсэн бөгөөд судалгаанд 6 м² талбай хамрагдсан. Өнгөн хөрснөөс доош 50 см гүнд хүртэл чулуун зэвсэг, ваарны хагархай, амьтны ясны хэлтэрхийнүүд нэлээд шигүү агуулсан бөгөөд 1, 2-р үеийн доод заагаар бор хүрэн өнгийн чулуурхаг хөрсний ялгарал илэрч байв. Чулуун

зэвсгийн олдворууд өнгөн хөрснөөс доош 50 см гүнд харьцангуй цөөрч байгаа нь ажиглагдсан болно.

Чулуун зэвсгийн олдворуудын анхдагч цуулалтын хэсэгт шаантган болон тайрдсан хэв шинжийн үлдцүүд, шовх үлдэц, харандаа маягийн үлдэц, бүх ирмэгийн дагууд цуулалт хийсэн призм хэв шинжийн эдлэлүүд зонхилно. Мөн цохилтын нэг талбайтай, цуулалтын нэг гадаргуутай, тэгш хэмт урт ялтас цуулан авсан зэрэгцээ ул мөрийг агуулсан үлдцүүд, төрөл бүрийн үлдэц хийхээр зассан бэлдцүүд, үлдцийн цохилтын талбай болон хажуу талыг дахин засах, боловсруулах явцад бий болсон техникийн цуулдаснууд олдсон байна.



Зураг-16. Зараа уулын Ил энгэрийн 2-р суурин. 3-р малтлага



Зураг-17. 3-р малтлагын явц



Зураг-18. 3-р малтлагын 1-р давхарга.
Ооль

Хоёрдогч боловсруулалт хийж ир гаргасан багаж зэвсгүүд нь залтас болон жижиг ялтсаар хийсэн янз бүрийн хусуурууд, ооль, хоёр талаас нь холтчин зассан бифас хэлбэрийн зэвсэг, цоолтуур, хатгуур, нэг талаас нь зассан унифас, холтослуур, ирлэсэн залтас, ялтас зэрэг нэлээд олон төрөл зүйлтэй юм. Мөн

малтлага болон газрын хөрсөн дээр нэг өргөн тал нь зүлгэгдэн үрэгдэж мөлийсөн хавтгай чулуунууд нэлээд илэрсэн нь самбар чулууны үүргээр хэрэглэгдэж байсан байх магадлалтай юм.

Мөн энэхүү сууринд өмнөх жилүүдэд хийсэн судалгааны явцад нэлээд олон тоогоор илэрсэн ооль хэлбэрийн зэвсэг энэ оны малтлагаас мөн хэд хэд илэрлээ. Зараа уулын Ил энгэрийн 2-р дурсгалт газарт хийсэн 3-р малтлагын 1-р давхаргаас зүлгэж мөлийлгөсөн, суурь буюу ирэн хэсэг нь хугарсан том хэмжээтэй ооль гарсан нь нэлээд сонирхолтой юм. Гол төлөв мод боловсруулах үүргээр хэрэглэгдэж байсан хэмээн үздэг ооль Зараа уулын шинэ чулуун зэвсгийн дурсгалаас олон илэрч байгаа нь голоцены эхэн болон дунд үед тухайн бүс нутаг мод элбэгтэй байсан хийгээд эртний оршин суугчид мод боловсруулах засах үйлд энэхүү зэвсгийг ашиглаж байсан хэмээн үзэхэд хүргэж байна. Мөн жижиг хэмжээтэй нухуур чулуу судалгааны хувьд нэлээд сонирхолтой бөгөөд Монгол орны шинэ чулуун зэвсгийн дурсгалуудаас нухуур болон нүдүүр нэлээд олддог боловч хэмжээгээр ийм жижиг эдлэл урьд өмнө олдож байгаагүй юм.

Шинэ чулуун зэвсгийн суурингийн малтлагын зэрэгцээ хуучин чулуун зэвсгийн үед холбогдох дурсгалуудыг өмнөх жилээс эхлэн судалж байгаа билээ. Одоогоор Зараа уулаас хуучин чулуун зэвсгийн үед хамаарах хоёр суурин илрүүлсэн бөгөөд нэг нь Зараа уулын зүүн хойд хэсэгт орших Зүүн Шовхын суурин, нөгөөх нь Зараа уулын дунд хэсэгт, Ил Энгэрийн өвөлжөөний баруун хойно орших Оцол хадны дурсгалт газрууд юм.

Оцол хадны суурин нь түүхий эдэд тулгуурласан суурин-дархны газар байх магадлалтай бөгөөд энд газар дээр чулуун зэвсэг хийх түүхий эд болон чулуун зэвсгийн олдворууд ш игүү тархжээ. Бид 100 x 100 см, 100 x 200 см хэмжээтэй хоёр сорилын малтлага хийсэн боловч өнгөн хөрснөөс доош чулуун зэвсгийн олдвор гараагүй. Тиймээс газар дээрээс сонголтын зарчмаар 167 ш олдвор түүвэрлэн цуглуулсан.

Оцол хадны палеолитын суурин



Зүүн Шовхын палеолитын суурин

Зураг-19. Зараа уулын палеолитын суурин

Цуглуулгын анхдагч цуулалтын хэсэг нь 9 ш эдлэлээр илэрхийлэгдэх бөгөөд тэдгээр нь *цохилтын нэг талбайтай, цуулалтын нэг гадаргуутай үлдэц*, ар тал руугаа налуу нимгэн гүдгэр цохилтын талбайтай, *леваллуа маягийн үлдэц*, арагша ялимгүй налуу жижиг цохилтын талбайтай, хажуу ирмэгүүдээс нь төв рүү чиглүүлэн цуулалт хийсэн үлдэц, зэрэгцээ цуулалтын зарчимт *хавтгай үлдэц* болон шаантган үлдэц хийхээр хажуу талуудыг нь хөндлөн цуучин ирмэг гаргаж зассан *бэлдэц* юм. Мөн үлдцийн цуулалтын гадаргуу болон хажуу талуудыг дахин засах явцад бий болсон техникийн цуулдас энэ ангилалд хамаарна.



Зураг-20. Оцол хадны палеолитын суурин

Хажуу ирмэгийг нь хайрслан холтчиж ирлэсэн *цуулдасны хугархай*, ирлэсэн баргил цуулдас нь тухайн дурсгалт газрын хоёрдогч засалт хийсэн багаж зэвсгийн төрлйн олдворыг илэрхийлж байна.

Цуулдасны үйлдвэрлэлийг залтас (70 ш), цуулдас (16 ш), ялтас (23 ш), хагархай хэлтэрхий (47 ш) бүрдүүлнэ. Ялтаснуудын дунд цахиур чулуунаас салган авсан хоёр талтай, тэгш бус хэмтэй ялтас болон шаантган маягийн үлдцийн хажууг дахин засах явцад бий болсон техникийн цуулдас цуглуулгад буй бусад олдворуудтай харьцуулахад харьцангуй хожуу үед холбогдоно.

Зараа уулын зүүн үзүүрийн өндөрлөгийн нутгийн олон Зүүн Шовх хэмээн нэрийдэх бөгөөд 2015 онд хуучин чулуун зэвсгийн дурсгал байгааг тогтоосон [Одсүрэн нар., 2016] бөгөөд 2016 онд цөөн тооны олдворыг сонголтын зарчмаар

түүвэрлэн цуглуулсан [Одсүрэн нар., 2016] билээ. Энэ онд олдворууд тархсан талбарт 100 х 100 см хэмжээтэй талбайд сорилын малтлага хийсэн. Малтлагын явцад 50 см гүнд хүртэл олдворууд илэрсэн бөгөөд 50 см гүнээс галын ором байж болох хар бараан толбо, түүний дээрээс амьтны ясны жижиг хэлтэрхий хэсгүүд илрүүлсэн. Энэ бүхэн нь тухайн дурсгал Монгол орны говь, хээрийн бүс нутагт ховор байдаг хуучин чулуун зэвсгийн соёлт давхаргатай суурин байж болохыг илтгэсэн тул дээж авч, дараа жил үргэлжлүүлэхээр төлөвлөж малтлагыг зогсоосон.



Зураг-21. Зүүн Шовхын палеолитын суурин

Мөн газар дээр тархсан чулуун зэвсгийн олдворуудаас 80 ш-ийг түүвэрлэн цуглуулсан бөгөөд төрөл зүйлийн хувьд үлдэц, багаж зэвсгийн зүйл, цуулдасны үйлдвэрлэл хэмээн ангилагдана.

Үлдцүүд нь хэв шинжээрээ цацраган цуулалтын арга барил бүхий том хэмжээтэй, налуу цохилтын талбайтай, зэрэгцээ цуулалтын арга барилт (зураг 2а-2) болон залтасаар хийсэн зэрэгцээ цуулалтын зарчимт хэмээн ангилагдана.

Багаж зэвсгийн төрөлд хянгар хамгийн олон буюу 9 ш байх бөгөөд тэдгээрийг залтас, цуулдас, ялтсаар хийжээ. Ирлэлтийн байдлаараа нэг хажуу ирмэг нь ирлэгдсэн, хоёр хажуу ирмэг нь ирлэгдсэн, конвергент иртэй, эсрэг захдаа иртэй, залтасны дугуйрсэн ирмэгийг босоо холтчин ирлэсэн (зураг 2а-1, 3, 5, 7, 8-10) хэмээн ангилагдана.




Зураг-22. Зүүн Шовхын палеолитын сууринд хийсэн сорьц малтлагаас илэрсэн галын ором

Мөн уртавтар тэгш өнцөгт маягийн чулууны хөндлөн богино ирмэгийг нэг талаас нь налуулан ирлэсэн *цүүц маягийн зэвсэг*, цуулдасны төгсгөлд өргөн ирмэгийг дотогш нь хүнхийлгэн ирлэсэн хүнхэр иртэй *холтослуур* маягийн зэвсэг (зураг 2а-6), босоо иртэй том *хусуур*, *хүнхэр иртэй зэвсэг*, *шүдлэг хүнхэр иртэй зэвсэг* (зураг 2а-4), *ирлэсэн ялтасны хугархай* (2 ш), *ир гаргасан цуулдас* (2 ш) зэрэг зэвсгүүд байна.

Цуулдасны үйлдвэрлэлд ялтас (зураг 2а-11) болон ялтасны хугархай (17 ш), цуулдас (6 ш), том жижиг хэмжээтэй залтас (34 ш), хагархай хэлтэрхий (6 ш) тус тус хамаарна.


Хуучин чулуун зэвсгийн суурингийн олдворуудын дунд леваллуагийн цуулалтын арга барил, дээд палеолитын үеийн чулуун зэвсэг үйлдвэрлэх арга барил ажиглагдаж байгаа бөгөөд бид Монгол орны зүүн бүс нутгийн нэлээд эрт үед хамаарах дурсгал байх боломжтой хэмээн үзэж байна.



Зураг-23. Зүүн шовхын палеолитын суурингийн чулуун зэвсгүүд. Хянгар-1, 3, 5, 7, 8-10; үлдэц-2, шүдлэг-хүнхэр иртэй зэвсэг-4; хүнхэр иртэй холтослуур маягийн зэвсэг-6, ялтас-11

5.2 Чулуун байгууламжит дурсгалын малтлага

Зараа уулын Ил энгэр орчмын улаан зуух хэлбэрийн чулуун байгууламжит дурсгалууд болон шинэ чулуун зэвсгийн олдворт газрууд хоорондоо холбоо хамааралтай эсэх нь ихээхэн сонирхолтой. Шинэ чулуун зэвсгийн олдворт газруудын ойр орчимд улаан зуух хэлбэрийн чулуун байгууламжит дурсгалууд байрлах байрлал зүйн нийтлэг дүр зураг Зараа уул болон Дэлгэрхаан ууланд ажиглагдсан билээ. Тиймээс судалгааны эх хэрэглэгдэхүүн бий болгох зорилгоор Зараа уулын Ил энгэрийн өвөлжөөний баруун талд, эргэн тойрон чулуун зэвсгийн олдвор тархсан газарт хойд зүгт чиглэсэн нэг эгнээд байрлах улаан зуух хэлбэрийн 3 дурсгалын хоёрыг малтав. Тэдгээрийг хойд захаас эхлүүлж ЕХ-01, 02, 03 хэмээн дугаарлав. Газар зүйн байршил нь хойд өргөргийн N46 07 48 8 зүүн уртрагийн E111 42 32 2 ба далайн төвшнөөс дээш 1043 метрт оршино.



Зураг-24. Ил Энгэрийн орчимд орших улаан зуух хэлбэрийн булш

ЕХ-01. Цувраа гурван булшны хойд захад оршино. Таруу дараастай бөгөөд төв хэсэгт нь тэгш өнцөгт хашлага мэдэгдэх боловч зарим булан, ирмэг нь мэдэгдэхгүйгээс үүдэн нарийн хэмжилт хийх боломжгүй байна. Дараасны ерөнхий

хэмжээ нь 450 х 450 см. Малтлагыг эхлүүлэхдээ булшны мэдэгдэж буй хашлаганы дагуу 500 х 600 см талбай татан өнгөн хөрсийг ойролцоогоор 5 см гүнд хуулав. Цэвэрлэгээний явцад гарсан бүх шороог шигшихэд цахиурлаг чулуугаар хийсэн цөөн тооны залтас болон үлдцийн хагархай илрэв. Зарим зэвсгийг харахад булшны дээд хэсэгт гаднын нөлөөгөөр (үерийн урсгал, мал амьтны хөлөөр?) зөөгдсөн байх магадлалтай ч нэг хэсэг зэвсгийн гадаргуу дээр цагаан өнгийн кальцийн карбонат болон нягт шороон бүрхүүл тогтсон байна. Өнгөн хөрсийг бүрэн хуулахад тархай дараасны төв хэсэгт байх хашлага нэлээд тодорсон. Хашлаганы хэмжээ 320 х 240 см. Зүүнээс баруун чиглэлтэй Тус хашлагыг нарийн хавтгай чулуудыг 2-3 үе давхарлан өрсөн бөгөөд өргөргийн дагуу чиглэлтэй ажээ.

Малтлагын ажлыг үргэлжлүүлэхдээ хашлага чулууны гадуур тарсан чигжээс чулууг авч үндсэн дөрвөлжин хашлагыг гарган баримтжуулсны дараа доош үргэлжлүүлэн малтахад өнгөн хөрснөөс доош 53 см гүнээс 185 урт, цээжин хэсэгтээ 70 см, голдоо 65 см, хөлдөө 50 см өргөн нүхний толбо илрэв. Толбо дотор үргэлжлүүлэн малтахад 70 см гүнээс нүхний толгой болон хөл талаас хөндлөнгөөр нь тавьсан хавтгай, нарийн таг чулуу гарав. Үүнээс гадна малтлагын явцад хавирга, сүүж, хүзүүний нугалам зэрэг хүний яс эмх замбараагүй байдалтай гарсан бөгөөд үүнээс доош 80 см гүнд нүүрийг нь урд зүгт, толгойг зүүн тийш хандуулан тавьсан түрүүлгэ нь харуулсан хүний оршуулга илрэв. Гавал таг чулуунд дарагдан бяцарч, цээжин хэсгийн яс нэлээд хөндөгдөн анхны байрлалаа алджээ. Хүний ясыг нүхнээс авах явцад цээжин хэсгээс хоёр, шигшүүрээс мөн хоёр ширхэг цагаан өнгийн жижиг сувс гарсан (тана чулуу буюу талькаар хийсэн байх магадлалтай). Өөр ямар нэг олдвор илрээгүй. Малтлагын нийт гүн 85 см. Оршуулгын нүхний хэмжээ: 185 см урт, дээрээ 70 см, дундаа 70 см, доороо 50 см өргөн. 3X 80 хэм



Зураг-25а. ЕХ-1-р булш (анхны байдал)



Зураг-25b. EX-1-р булшны хашлага ба дараас



Зураг-26. EX-1-р булш. Оршуулгын нүх илэрсэн байдал



Зураг-27. EX-1-р булш. Оршуулга

EX-02. Өмнөх булшны чанх урд талд 5 метрт байрлана. Булшны дараас болон хашлага чулуу ихэд тарж анхны хэлбэрээ нилээд алдсан бөгөөд хашлаганы зүүн урд булан мэдэгдэхээргүй болжээ. Хашлага чулууны голд том хавтгай чулуудыг хашлаганы хананы уртааш дагуу босгож тавьсан байх ба булшны дараас чулууг, эсвэл хашлаганы хавтгай чулуун зөөж хожим босгож тавьсан бололтой байна.


Өнгөн хөрсийг цэвэрлэн баримтжуулан хашлага чулууны гадуур тарсан чулууг авч доош малтах явцад 38 см гүнээс, хашлаганы зүүн булангийн гадна талаас адууны яс болон зарим хугархай яс гарав. Булшны ерөнхий хэлбэрийг гарган баримтжуулсны дараа малтлагыг хашлага дотор үргэлжлүүлэхэд хашлаганы төв хэсэгт мэдэгдэж байсан хайрцаглан тавьсан чулууны голоос баруун зүгт толгойг хандуулсан, дээш нь харуулж тэнэгээр байдлаар тавьсан нэгэн оруулмал оршуулга илэрсэн. Хөл гарын зарим үеэс бусад яснууд анхны тавилтаараа байна. Нас барагчийн баруун мөрний дээрээс бог малын нэг шагай илрэв. Уг оршуулгыг баримтжуулан авсны дараа малтлагыг хашлага дотор үргэлжлүүлэв. 50 орчим см гүнээс баруунаас зүүнд чиглэлтэй цувраа чигжээс чулуу оршуулгын нүхний толбо дотор илрэв. Тус чигжээс чулууны дор 67 см гүнээс дахин чигжээс чулуун үе мэдэгдэв. Нүхний дээд хэсэгт толгойн таг чулуу бололтой нимгэн хавтгай чулуу байсан ба нүхний төв хэсгээс доош нэлээд хэдэн чигжээс чулуу гарлаа. Тэдгээр чулуун дундаас бод малын хурууны үе 1 ширхэг, бог малын хүзүүний үеийн 1 хугархай тус тус гарав. Чигжээс чулууг аван доош малтахад түрүүлгээр нь харуулж оршуулсан хүний оршуулга илэрсэн юм. Ясны хадгалалт тун тааруу ч анхны тавилтаараа байна. Харин хөл гарын зарим үеүд мэрэгчийн хөлд зөөгдөн ийш тийш таржээ. Оршуулгын нүхний хэмжээ: 185 см урт, дээрээ 70 см, дундаа 65 см, доороо 50 см өргөн. Оршуулгын нүхний чиглэл ЗХ 80 хэм.



Зураг-28. ЕХ-2-р булш (анхны байдал)



Зураг-29. ЕХ-2-р булш.



Зураг-30. EX-2-р булшны хашлага ба дараас



Зураг-31. EX-2-р булш. Оруулмал оршуулга



Зураг-32. EX-2-р булш. Оршуулгын нүх



Зураг-33. 2-р булш. Оршуулга



Зураг-34. 2-р булшны хашлаганы гадна талаас илэрсэн адууны шүд

ЕХ-03. Ил энгэрийн зүүн талд байх сайрын зүүн талд баруунаас зүүнд жижиг толгод үргэлжлэх ба түүний хойноос мушгиран зүүн тийш сунах толгойн урд налуу энгэрт уг булш оршино. Тус булш нь битүү, овгор чулуун дараастай. Дараас чулуу налууд ихэд тарж анхны хэлбэрээ алдсан ч түүний дөрвөлжин хашлага бага зэрэг мэдэгдэнэ. Хашлаганы хойд хана урагш нумарсан байх агаад хэлбэрт булшийг санагдуулна.

Өнгөн хөрсний цэвэрлэгээг 750 x 650 см талбайд хийх явцад гарсан хөрсийг шигшиж үзэхэд улаан, хүрэн бор өнгийн ваарын хагархайнууд, цахиурлаг чулуугаар хийсэн ялтас болон мал амьтны ясны жижиг хугархайнууд гарч байв. Малтлагыг цааш үргэлжлүүлэхдээ бид хашлаганы гадуур тарсан чулуудыг зайлуулж булшны ерөнхий хэлбэрийг гаргав. Хашлага тэгш өнцөгт хэлбэртэй бөгөөд өргөргийн дагуу

чиглэлтэй. Хэмжээ 470 x 420 см. Хойд ханыг хавтгай/хавтгайдуу боржин чулуу ашиглан дээш 3-4 үе, дотогш 2 үе(?) өрж босгосон бол зүүн болон баруун ханыг ерөнхийдөө дунд зэргийн хэмжээтэй чулууг дангаар (зүүн ханыг дотогш нэг үе давхарлан тавьсан байх магадлалтай) газарт эгнүүлэн тавьж дээр нь чулуу өрж тавьсан бололтой байна. Дараас чулуу нурсны улмаас чухам дээш хэдэн өрлөгтэй байсныг хэлэхэд хэцүү болжээ. Харин хашлаганы урд ханыг тодорхойлоход жаахан түвэгтэй байв. Учир нь хана нь дараас чулуутай холилдон газрын хэвгийг нэгдүгээрт нурж, хоёрдугаарт тонуулчдын гараар ихэд эвдэгджээ. Зүүн хашлаганы төв хэсгийн гадна талд (хашлагатай залгаа) нэгэн хөшөө чулуу байна. Хэмжээ 82 см өндөр, 46 см өргөн, 25 см орчим зузаан.




Зураг-34. 3-р дурсгал (анхны байдлаар)



Зураг-35. 3-р дурсгалын малтлага

Малтлагын явцад хашлаганы гадна талаар 40-50 см орчмын гүнээс мал амьтны яс, ваар савын хагархай нэлээд хэд олдлоо. Хашлаганы баруун урд булангийн гадна талд, булангийн чулууны ёроолын хананд босоогоор наалдсан нэг, түүний урд газарт нэг ваарын том хагархай тус тус гарав. Гүн нь 44 см. Мөн зүүн хананы гадна талаас улаан өнгийн ваарын жижиг хагархайнууд илэрч байв. Хойд ханын гадуур 45 орчим см-ийн гүнээс төв болон зүүн биеэс адууны шүдний хугархай болон бусад ясны хугархай гарсан бөгөөд тонуулын явцад оршуулгын нүхнээс гарсан байх боломжтой юм. Үүний дараагаар малтлагыг дөрвөлжин хашлага дотор үргэлжлүүлэхэд хашлаган дотор, гол хэсэгт нь 40 см гүнээс 220 x 120 см хэмжээтэй чулуун чигжээсэн үе гарсан бөгөөд үүнийг баримтжуулан доош малтахад 50 орчим см гүнд оршуулгын толбо илрэв. Хэмжээ нь 227 см урт, дэд хэсэгт 83 см, дундаа 75, доороо 63 см өргөн байв. Нүхэнд малтлагын хийхэд 89 гүнээс хүний сүүжний ясны хугархай чигжээс чулуунуудын хамт гарав. Чигжээс чулууг авч доош шалгахад 104 см гүнээс байгалийн эх хөрс гарч бид малтлагын ажлыг зогсоолоо. Оршуулгын нүх зүүн хойш 80 хэмд чиглэжээ.

ЕХ-04. Бидний малтлага судалгаа хийж буй Зараа уул-2 хэмээн тэмдэглэсэн шинэ чулуун зэвсгийн суурингийн урд талд, жижиг чулууг тойруулан өрж тавьсан 60 см голч бүхий нэгэн чулуун байгууламж бий. Тус байгууламж нь голдоо чулуугүй ба хүрээний гадуур цөөн хэдэн чулуун таржээ. Өнгөн хөрсийг 300 х 230 см талбайд цэвэрлэж шороог шигшин үзэхэд чулуун зэвсгийн зүйлс цөөн тоотой гарав. Холбогдох баримтжуулалт гүйцэтгэсний дараагаар бид малтлагыг байгууламжийн төв үйлдсэн бөгөөд 15 см орчим гүнээс амьтны ясны жижиг хугархайнууд олдов. Улмаар байгууламжийг бүх чулуун авч 140 х 140 талбайд доош малтан үзэхэд, ямар нэг олдвор хэрэглэгдэхүүн болон тодорхой тахил тайлгын шинэ тэмдэг илрэлгүй байгалын ул хөрсөнд тулж малтлагын ажлыг зогсоолоо.



Зураг-36. ЕХ4-р дурсгалын дараас

6. ТОВЧ ҮР ДҮН

“Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа” төслийн 2017 оны хээрийн судалгааг шинэ дурсгал илрүүлэх зорилготой хайгуул, чулуун зэвсгийн суурингийн малтлага, чулуун байгууламжит дурсгалуудын малтлага судалгаа гэсэн чиглэлд амжилттай хийж гүйцэтгэв.

Хайгуул судалгааны үр дүнд Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын нутаг Онгон элсний Баруун булагаас шинэ чулуун зэвсгийн суурин, дараасгүй гүехэн нүхэнд оршуулсан эртний нүүдэлчдийн оршуулга, Онгон элсний баруун урд зах, Адуун худагаас хуучин болон шинэ чулуун зэвсгийн суурин, Онгон сумын төвөөс зүүн урагш орших Энгэр шар бүрд, Хөндлөнгийн гол зэрэг газруудаас шинэ чулуун зэвсгийн дурсгал илрүүлэн барримтжуулсан байна. Шинээр илрүүлсэн дурсгалууд эртний томоохон нуур, голын сав дагууд булаг шандтай буюу баянбүрдэд түшиглэсэн байршил зүйн нийтлэг байдал ажиглагдаж байна. Бидний хайгуул судалгаанд хээрийн бүс нутгийн өмнөд хэсгийн элсэрхэг хөрс бүхий нутаг дэвсгэр хамрагдсан бөгөөд задгай ил усны ундаргад түшиглэсэн амьдралын хэлбэр зонхилж байсан бололтой. Мөн чулуун зэвсгийн олдворууд хатуу шаварлаг хар өнгийн хөрсөн дээрээс нэлээд олдож байгаа бөгөөд голоцены дараах үед тухайн бүс нутаг чийгшил ихтэй, үржил шимтэй газар байсныг илтгэж байна.

Салаа булагт хийсэн малтлагаар энэхүү хар бараан өнгөтэй шаварлаг хөрснөөс олон тооны чулуун зэвсгийн олдвор, тэр дундаа шинэ чулуун зэвсгийн төгсгөл үед холбон үзэх боломжтой хоёр талаас нь холтчин зассан сумны чулуун зэвүүд, жижиг болон бичил ялтас, зуулга ир илэрсэн. Салаа булагийн суурингийн чулуун зэвсгийн олдворуудын хэв шинж, цуулалтын арга барилд үндэслэвэл, шинэ чулуун зэвсгийн дундаас хойших үед хамаарах бололтой. Энхүү суурин нь тухайн бүс нутгийн эртний анчин, түүвэрлэгчдийн түүхийг тодруулах чухал хэрэглэгдэхүүн бүхий томоохон дурсгал гэдгийг энэ удаагийн сорьц малтлагаар тодорхойлсон.

Зараа уулын Ил энгэрийн орчимд, өмнөх жилүүдийн малтлага судалгааг үргэлжлүүлэн хийсэн бөгөөд хөрсний дөрвөн давхаргаас чулуун зэвсгийн олдворууд амьтны ясны хэлтэрхий, хугархай, шавар ваар савны олдворууд илрүүлсэн бөгөөд лабораторийн нарийвчилсан шинжилгээний ажлууд хийгдэж байна.

Малтлагаас илэрсэн чулуун зэвсгийн олдворуудын анхдагч цуулалтын хэсэг нь цөөн тооны бэлдэц, үлдэц, техникийн цуулдсаар илэрхийлэгдэнэ. Үлдцүүдийн ихэнх нь цохилтын талбайг нь холтчин бэлтгэсэн, шовх суурьтай, цуулалтын гадаргуудаа тэгш хэмтэй, жижиг болон бичил ялтас цуулсан зэрэгцээ ором

хадгалсан тайрдсан хэв шинжид хамаарах юм. Мөн нэг хажууг ар, өвөр талаас нь хөндлөн цуучих, холтчих аргаар засаж хурцалсан шаантган үлдэц хэд хэд илрүүлсэн байна. Үлдцийн бусад төрлөөс цуулалтын нэг гадаргуутай, цохилтын нэг талбайтай үлдэц болон харандаа хэлбэрийн үлдэц цөөхөн илэрч олджээ. Үлдцүүд нь бэлтгэгдсэн арга барил, хэв шинжээрээ хоорондоо ялимгүй ялгаатай ч бүгд ялтас цуулж авах зорилгоор бэлтгэгдсэн нийтлэг байдалтай ажээ.

Зэвсгийн төрөл зүйлд шинэ чулуун зэвсгийн бусад дурсгалт газрын нэгэн адил хусуур хамгийн олон тоотой байна. Хуучин чулуун зэвсгийн үеэс өргөн тархсан энэ төрлийн зэвсэг нь хийхэд хялбар бөгөөд маш өргөн хүрээнд тархсан байдаг. Энэ оны малтлагаас илэрсэн хусуур зэвсгийн ихэнхийг залтас ашиглан хийсэн бөгөөд төгсгөл ирмэгийг нь дугуйруулан босоо болон налуу холтчин ирлэсэн байна. Багаж зэвсгийн бусад төрөл болох цоолтуур, сийлүүр, хоёр талаас нь боловсруулсан (бифас) зэвсгийн хугархай, сумны зэв зэрэг олдворууд илэрч олдсон.

Малтлага судалгааны явцад амьтны ясны жижиг хэсгүүд олноор илэрч олдсон бөгөөд тэдгээрийн төрөл зүйлийг тодорхойлох, хөрсний үе давхаргуудын он цагийг тогтоох зорилгоор лабораторийн судалгаанд илгээгээд байна.

Энэ оны хээрийн судалгааны явцад зараа уулаас хуучин чулуун зэвсгийн үед хамаарах 2 дахь сууринг илрүүлсэн бөгөөд газрын нэршлийг баримтлан Оцол хадны хуучин чулуун зэвсгийн суурин хэмээн нэрлээд байна.

Энд газрын хөрсөн дээр хуучин чулуун зэвсгийн хэв шинжийг хадгалсан олдворууд нэлээд нягт тархсан бөгөөд ихэнх нь чулуун зэвсэг цуулалтын явцад гарсан хагархай хэлтэрхий байна. Оцол хадны сууринд бага хэмжээний сорьц малтлага хийхэд соёлт давхаргагүй ил суурин болох нь тогтоогдлоо.

Мөн хамтарсан төслийн хүрээнд өмнө нь илрүүлсэн Зараа уулын Зүүн Шовхын палеолитын сууринд сорьц малтлага хийхэд 60 см орчим гүнээс галын ором байж магадгүй хэсэг илэрсэн бөгөөд бид соёлт давхаргатай суурин байж магадгүй хэмээн таамаглаж байна.

Хуучин чулуун зэвсгийн суурингийн олдворуудын дунд леваллуагийн цуулалтын арга барил, дээд палеолитын үеийн чулуун зэвсэг үйлдвэрлэх арга барил ажиглагдаж байгаа бөгөөд Монгол орны зүүн бүс нутгийн нэлээд эрт үед хамаарах дурсгал байх магадлалтай байна. Чулуун зэвсгийн олдворуудын хэв шинж, цуулалтын арга барил нь Монголын төв хэсгийн Орхон-1, Орхон-7 болон Өвөр Монголын зүүн хойд хэсэг, Монгол, БНХАУ-ын хилээс холгүй орших Жинстэйн агуйн дурсгалтай ихээхэн адилсаж байгааг хэлэх хэрэгтэй.

Чулуун байгууламжит дурсгалын судалгаанд улаан зуух хэлбэрийн булш 2, дөрвөлжин хэлбэрийн битүү намхан дараастай булш, чулуун байгууламж хамрагдсан бөгөөд улаан зуух хэлбэрийн блшнуудаас түрүүлгэ нь харуулан оршуулсан оршуулга илэрлээ. Малтлага судалгаа хийсэн эдгээр дурсгалуудын насжилтыг лабораторийн судалгаагаар тогтоохоор бэлтгэж байна. Бид ирэх жилүүдэд шинэ чулуун зэвсгийн дурсгалуудтай байршил зүйн хувьд давхцаж буй чулуун байгууламжит дурсгалуудын малтлагыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байна.

7. НОМ ЗҮЙ

Амартүвшин нар., 2012 – Амартүвшин Ч., Батболд Н., Эрэгзэн Г., Базаргүр Д., Эрдэнэ Б., Амгалантөгс Ц., Галдан Г., Буянхишиг Ц., Дашдорж Б., Пүрэвжал Х. Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутаг дахь “Засаг Чандмань Майнз” ХХК-ийн ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Чандмань Хар уул” талбайд 2012 оны намар хийсэн археологийн малтлага судалгааны ажлын тайлан. Улаанбаатар. ТАХБМТ.

Амартүвшин нар., 2013 – Амартүвшин Ч., Галдан Г., Одсүрэн Д., Бөхчулуун Д. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан уул: Монгол-Америкийн хамтарсан “Дорнод Монгол: археологийн хайгуул судалгаа” төслийн хээрийн шинжилгээний ажлын тайлан. Улаанбаатар. ТАХБМТ.

Букинич, 1934 – Букинич Д.Д. Общий отчет по археологические работы за 1933-1934 г.г. Улаанбаатар. ТАХБМТ.

Гурван гол, 1990, 1991, 1992, 1993 - Gurvan Gol - Archaeological Research. A report on the joint investigation under the Mongolian and Japanese “Gurvan Gol” historic relic probe project. /1991-1993/. Tokyo.

Гүнчинсүрэн, 2000 – Гүнчинсүрэн Б. Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн он цагийн асуудлыг дахин авч үзэхэд // Археологийн судлал. Том. XX, fasc.2. Улаанбаатар.

Гүнчинсүрэн нар., 2012 – Гүнчинсүрэн Б., Базаргүр Д., Эрэгзэн Р., Алдармөнх П. Монгол-Солонгосын хамтарсан чулуун зэвсгийн судалгааны ангийн 2012 оны хээрийн шинжилгээний тайлан. Улаанбаатар. ТАХБМТ.

Доржсүрэн, 1957а – Доржсүрэн Ц. 1955 онд Төв ба баруун аймгуудад археологийн шинжилгээ хайгуулын ажил явуулсан тухай. ШУХБ. НУА. №2. Улаанбаатар.

Дорж, 1969 – Дорж Д. Дорнод Монголын неолитын үеийн булш сууц. // Шинжлэх Ухааны Академийн мэдээ. №3. Улаанбаатар.

Дорж, 1971 – Дорж Д. Неолит Восточной Монголии. Улан-Батор.

Ларичев и др., 1964 – Ларичев В.Е., Волков В.В. Мустиерские и неолитические памятники Южной Гоби <<Древняя Сибирь>> вып. 1 Новосибирск.

Намнандорж, 2003 – Намнандорж О. Бүтээлийн эмхтгэл. Улаанбаатар.

Одсүрэн нар., 2016 –Одсүрэн Д., Бөхчулуун Д., Яанз Л., Розен А. “Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа” төслийн 2016 оны хээрийн шинжилгээний ажлын үр дүн // Монголын археологи-2016. УБ., 2017.

Окладников, 1951 – Окладников А.Д. Новые данные по древнейшей истории Внутренней Монголии. ВДИ, № 4.

Окладников и др., 1982 – Окладников А.П., Васильевский Р.С. Новые исследования Аршан хаде в Монголии. Изв. СО АН СССР. № 6, Вып. 2, Серия общественных наук. Новосибирск.

Цогтбаатар, 1994 – Цогтбаатар Б. Ханангийн чулуун зэвсгийн дурсгал // Археологийн судлал. Том. XIV, fasc.2, Улаанбаатар.

Цогтбаатар, 1998 – Цогтбаатар Б. Бугахайрханы хуучин чулуун зэвсгийн дурсгал // Археологийн судлал. Том. XVIII, fasc.4, Улаанбаатар.

Цогтбаатар нар., 2003 – Цогтбаатар Б., Амартүвшин Ч., Болдхуяг Д., Гантулга Ж., Эрдэнэ Б. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Хөдөө арал орчимд хийсэн археологийн хээрийн шинжилгээний ажлын тайлан. Улаанбаатар. ТАХГБСХ.

Цогтбаатар нар., 2010 – Цогтбаатар Б., Болорбат Ц., Одсүрэн Д. Улаан хадны чулуун зэвүүд // Археологийн судлал. Том. (IX) XXIX, fasc.3. Улаанбаатар.

Цогтбаатар нар., 2012 – Цогтбаатар Б., Одсүрэн Д., Ишцэрэн Л. Монгол-Японы хамтарсан “Монголчуудын палеоантропологиян судалгаа” төслийн 2012 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. Улаанбаатар. ТАХБМТ.

Цогтбаатар, Пүрэвжал, 2014 – Цогтбаатар Б., Пүрэвжал Х. Ачаат уулын чулуун зэвсгийн суурин // Археологийн судлал. Том. XXXIV, fasc.2. Улаанбаатар.

Цыденова и др 2012 – Цыденова Н.В., Тумэн Д., Эрдэнэ М. Древнее поселение Барга элс в Восточной Монголии // Древние Культуры Монголии и Байкальской Сибири. Улаанбаатар

Mania, 1963 – Mania D. Archaeologische Studien in der zentralen Mongolei, Sonderdrucke aus der Wissenschaftlichen Zeitschrift der Martin-Luther-Universität Halle-Wittenberg. Heft 13.

Izuho, et al., 2005 – Izuho Masami, Tsogtbaatar Batmunkh, Tsurumaru Toshiaki. Mongol Tobu, Khenty Ken no Kyusekki Iseki Ipan Chosa Hokoku [Report of a Expedition of Paleolithic site at Khenty province, eastern Mongolia]. *Dai 6 Kai Kita Asia Chosa Kenkyu Hokoku Kai Yokoshu* [Abstracts for the 6th Annual meeting of the Research Association of the North Asia], pp.55-58. *The Research Association of the North Asia, Tokyo. (In Japanese)*

БАТЛАВ. С.ЧУЛУУН

ШУА-ИЙН ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ,
ДОКТОР, ПРОФЕССОР

**МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН “ГОВЬ-ТАЛ ХЭЭРИЙН БҮСИЙН
НЕОЛИТЫН СУДАЛГАА” ТӨСЛИЙН 2017 ОНЫ ХЭЭРИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН УДИРДАМЖ**

2017.03.03.

Судалгааны зорилго:

Монгол орны говь, хээрийн бүс нутгийн шинэ чулуун зэвсгийн дурсгалуудыг судалж холбогдох он цагийн хамаарлыг лабораторийн судалгаанд түшиглэн тодорхойлох, чулуун зэвсэг үйлдвэрлэлийн онцлог, эрхлэх аж ахуйн судалгааны асуудлыг шинэ хэрэглэгдэхүүнээр баяжуулахад энэхүү төслийн зорилго оршино. Энэ онд Зараа уулын шинэ чулуун зэвсгийн суурингийн малтлага судалгааг үргэлжлүүлэх ба өмнөх судалгааны үр дүнг бататгах, шинэ эх хэрэглэгдэхүүн бий болгоход чиглэгдэнэ.

Газарзүйн байршил: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Зараа ууланд солбицол: N46 07 45.3 E111 42 33.3 малтлага судалгаа, Хэрлэн голын сав дагуу Хэнтий, Дорнод аймгийн нутгаар хайгуул судалгаа хийнэ.

Судлагдсан байдал:

Говь, тал хээрийн бүс нутгийн шинэ чулуун зэвсгийн дурсгалуудын судалгаа 1920-иод онд эхэлжээ. 1922, 1923, 1925-1928 онуудад Р.Ч.Эндрюсийн удирдсан Америкийн “Төв Азийн экспедици” Монгол орны өмнөд болон баруун өмнөд хэсэгт ажиллаж, Улиастайгаас Хаалган хүртэлх зурвас газраас 180 гаруй дурсгалт газар илрүүлсний ихэнх шинэ чулуун зэвсгийн үед холбогдохыг судлаачид тэмдэглэсэн байна. Эдгээрээс баялаг олдвор бүхий томоохон дурсгал нь Баянцагийн шинэ чулуун зэвсгийн суурин юм. 1933-1934 онуудад археологич Д.Д. Букинич Халхын голын сав дагууд хайгуул хийж хэд хэдэн суурин илрүүлсэн мэдээ бий. 1949 онд Монгол-Зөвлөлтийн Түүх, Соёлын Хамтарсан экспедицийн чулуун зэвсгийн дурсгал судлах хэсэг Дорнод Монголын Хэрлэн, Халх голын сав, Буйр нуур орчмоор хайгуул судалгаа хийсэн бөгөөд Тамсагбулагийн дурсгалт газрыг илрүүлжээ. 1955 онд Монголын говийн бүс нутгийн шинэ чулуун зэвсгийн үед холбогдох томоохон дурсгал Дулааны говийн сууринг илрүүлсэн бөгөөд хожим 1978 онд дахин судалгаа хийжээ. 1954 онд О.Намнандорж Сүхбаатар аймгийн Урт сумын нутаг Долир манхан, Их айлын манхнаас хас болон цахиур чулуугаар хийсэн шинэ чулуун зэвсгийн хэв шинж бүхий олдворууд түүвэрлэсэн байна. 1953-1955 онд Х.Пэрлээ Хэнтий аймгийн Гүрэмийн нуурын орчмоос шинэ чулуун зэвсгийн хэв шинж бүхий шавар ваарны хагархай, галын ором, чулуун зэвсгийн олдвор, Хэрлэнгийн баруун эрэгт орших Баянцогт овооноос шинэ чулуун зэвсгийн суурин илрүүлжээ. Мөн энэ үед нутгийн иргэдийн оролцоотойгоор Молцог элсний дурсгал, Устай, Бургастайн шинэ чулуун зэвсгийн томоохон дурсгалуудыг илрүүлсэн байна. 1960-1970-аад оны үед Монгол орны хээрийн бүс нутагт шинэ чулуун зэвсгийн судалгаа харьцангуй эрчимтэй хийгдсэн бөгөөд Сүхбаатар аймгийн Бүрдийн баруун эрэг, Онгон элсний зүүн хэсэг, Онгон сумын төвийн баруун тал, Хонгор сумын Гүн булаг, наран сумын Эхэн ус, Дорнод аймгийн Хэрлэнгийн эргийн дурсгалууд, Овоот, Баруун, Зүүн

Хавсралт-1. Хээрийн судалгааны ажлын удирдамжийн хуулбар

Өлзийт, Дөрөө нуур, Ямаат нуур, Тогоот нуур, Мөнх толгой, Баруун шорвог нуур, Хүйтэн булаг зэрэг газруудаас шинэ чулуун зэвсгийн дурсгал илрүүлжээ.

1990-ээд оны эхэн үед “Дорнод Монгол” төслийн хүрээнд Монгол, Солонгосын судлаачид Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Молцог элсний орчимд бага хэмжээний малтлага хийжээ. Монгол-Францын хамтарсан экспедици 1998 онд Тамсагбулагийн дурсгалт газарт ажиллажээ. Сүүлийн жилүүдэд МУИС-иас зохион байгуулсан “Дорнод Монгол” экспедицийн хүрээнд Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг Ваарт элс, Түвшинширээ сумын нутаг Тогоотын голд малтлага судалгаа хийж байна. Монгол-Америкийн хамтарсан “Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа” төслийн хүрээнд 2013 онд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Дарьганга сумын Молцог элс орчимд хайгуул судалгааг гүйцэтгэсэн бөгөөд Дэлгэрхаан уул орчимд Булагийн эхэн, Дунд булаг, Адагийн булаг, Тогоотын гол, Дэлгэрхаан уулын зүүн урд орших эртний нуурын савын ар, Зараа уул, Улаан зуух, Молцог элс орчимд Өлзийн булаг, Салаа булаг, Ганга нуурын зүүн эрэг, Сүмтийн нуур зэрэг газруудаас чулуун зэвсгийн дурсгалт газруудыг илрүүлсэн байна. Мөн 2015 онд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Зараа уулын шинэ чулуун зэвсгийн сууринд малтлага судалгааны ажил гүйцэтгэжээ.

Судалгааны арга:

Археологийн хээрийн шинжилгээний малтлага болон хайгуул судалгааны арга зүйг ашиглах ба илэрсэн олдвор хэрэглэгдэхүүний гар зураг болон бусад баримтжуулалт үйлдэнэ.

Хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүн:

Монгол улсын талаас:

1. Ч.Амаргүвшин (Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, дэд профессор)
2. Д.Одсүрэн (Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан)
3. Д.Бөхчулуун (Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан)
4. Т.Чинзориг (жолооч)

Америкийн талаас:

1. Л.Жанз (Канад улсын Трентийн Их сургуулийн багш, доктор (Ph.D)).
2. А.Розен (АНУ-ын Техасийн Их Сургуулийн Антропологийн тэнхимийн доктор (Ph.D), профессор).

Унаа машин: Ланд Крузер

Маршрут, Хугацаа:

Улаанбаатар – Өндөрхаан – Түвшинширээ – Өндөрхаан – Улаанбаатар.

Хугацаа:

2017 оны 06-р сарын 15-наас 07-р сарын 20-ныг хүртэл.

Санхүүжилт:

Franklin Research Grant

Багаж тоног төхөөрөмж, машин техник:

- Археологийн малтлагын багаж хэрэгсэл
- Олдвор, дээж хэрэглэгдэхүүний уут

- Майхан
- Гал тогооны хэрэгсэл
- Автомашин

Судалгааны урьдчилсан үр дүн:

Малтлага судалгааны явцад шинэ олдвор хэрэглэгдэхүүн илрүүлж нарийвчлан судлах. Тус экспедицид оролцсон талууд хамтран малтлага судалгаагаар олдсон хэрэглэгдэхүүнд боловсруулалт хийж, мөн малтлага судалгааны явцад илэрсэн дурсгалуудын талаар урьдчилсан үр дүнг мэдээлж, эрдэм шинжилгээний тайлан бичиж хүлээлгэн өгнө.

Удирдамж боловсруулсан:

Д.Одсүрэн

Эрдэм шинжилгээний ажилтан
Д.Одсүрэн

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

ТЭМДЭГЛЭЛ БИЧСЭН:

.....
/албан тушаалын нэр/
..... /гарын үсэг/ /нэрийн тайлал/
..... /тэмдэг/

2017 оны ... сарын ...-ны өдөр

МОНГОЛ УЛС
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМ

ПАЛЕОНТОЛОГИ, АРХЕОЛОГИЙН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХАЙГУУЛ,
МАЛТЛАГА СУДАЛГААНЫ АЖИЛ ХИЙХ

ЗӨВШӨӨРӨЛ

Улаанбаатар хот
2017 он

№ 1-05

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН 2017 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18 НЫ
ӨДРИЙН А/205 ТООТ ТУШААЛАР
Түүх, археологийн курсын -ийн

Э. Амартүвшин удирдагчтай
иоомтын СУДАЛГААНЫ АНГИД
ПАЛЕОНТОЛОГИ, АРХЕОЛОГИЙН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХАЙГУУЛ, МАЛТАЛГАА
СУДАЛГААНЫ АЖИЛ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОВ.

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН
МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Т. ГАН-ЭРДЭНЭ /нэрийн тайлал/
/гарын үсэг/

УХАА 138
16136429 0716631

2017 оны 05 сарын 18-ны өдөр

СУДАЛГААНЫ АЖИЛ ХИЙХ:

Засаг захиргааны нэгжийн нэр:

Сүхбаатар аймаг
Түвшинширээ сум

Газар нутгийн нэр:

Зарга уул

Дурсгалын нэр:

Шинэ суурин дэвсгэлийн суурин

Солбицол:

Хугацаа: 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдөр
2017 оны 07 дугаар сарын 20-ны өдөр

Энэхүү зөвшөөрөл нь зөвхөн зөвшөөрөлд бичигдсэн
газар, хугацаанд хүчинтэй.

Яаралтай үед холбогдох утасны дугаар:
51-263181, 8898-5777

Хавсралт-2. Хээрийн судалгааны ажлын зөвшөөрлийн хуулбар

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөгт хээрийн шинжилгээний ажлын тайлан хүлээлгэн өгсөн баримт

Д.Одсүрэн, Д.Бөхчулуун, Л.Яанз, А.Розен нарын хамтран бичсэн “Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа” төслийн 2017 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан

Нийт 54 тал

Фото зураг- 35

Гар зураг- 6

Хүлээлгэн өгсөн

ЭША. /Д.Одсүрэн/

Хүлээн авсан

2018 оны 02 дүгээр сарын 09